

ШИВЭЭГОВЬ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэгдүгээр бүлэг. СУМЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

1.1. Сумын тухай ерөнхий ойлголт

Улсын Бага Хурлын 1931 оны 5 дугаар тогтоолоор хошуудыг татан буулгаж, 13 аймгийг шинээр байгуулахад Оцол сансар уулын хошууны нутаг Хэнтий, Төв, Дорноговь аймагт хуваагдахад Төв аймгийн Говьсүмбэр (одоогийн Сүмбэр) сум байгуулагджээ. Тус сум 1931-1956 онд буюу 25 жил Төв аймгийн 1956-1991 онд буюу 35 жил Дорноговь аймгийн харьяалалд байжээ. Улсын Бага хурлын 1991 оны 6-р сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолын дагуу Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын харьяанд байсан Баянтал хороог нэгтгэж, Сүмбэр сумын хилийн цэс дотор Чойр хотыг 1991 оны 8 дугаар сард шинээр байгуулжээ.

Шивээговь сум нь Улаанбаатар хот, БНХАУ болон ОХУ-тай засмал зам болон төмөр зам, шилэн кабелиар холбогдсон нь орчин үеийн холбоо мэдээллийн салбарын дэвшилтэт технологийг ашиглах бололцоотой бөгөөд мөн байнгын эрчим хүчний системд холбогдсон дэд бүтэц сайн хөгжсөн сум юм. Шивээговь сум нь аймгийн төвөөс зүүн урагш 34 км-т орших бөгөөд зүүн талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан сум, баруун талаараа Дундговь аймгийн Баянжаргалан сум, хойд талаараа Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумдтай хиллэнэ.

1.2. Сумын байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл

1.2.1. Газрын гадарга

Тус сумын нутаг дэвсгэр нь цөл, цөлөрхөг хээр ба хуурай хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд эрс тэс уур амьсгалтай, тэгш өндөрлөгтэй тал хөндийд, энд тэнд бага зэрэг тархсан нам хотос бүхий нутаг юм.

1.2.2. Ус зүй

Байгаль орчин аялал жуулчлалын яамны судалгаагаар Говьсүмбэр аймаг нь 0.01км.куб гадаргын ус, 0.001 км.куб газрын доорхи усны нөөцтэй гэж тогтоогджээ.

Говьсүмбэр аймаг нь усан хангамжын хувьд хангалттай биш. Аймгийн нутаг дахь цөөн тооны булаг шанд горхи нь ундрага багатай. Ус зүйн сүлжээний хувьд аймгийн нутаг дэвсгэрийн багахан хэсэг нь (нутгийн зүүн хойно Хэрлэн голын сав) номхон далайн ай савд үлдсэн хэсэг нь төв азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг.

Бэлчээрийн болон ундны цэвэр усны хангамжид худаг ихээхэн нөлөөтэй. Унданд ашиглагдаж байгаа газрын гүний ус нь хатуулаг ихтэй, эрүүл ахуйн шаардлага хангадаггүй, нутгийн хүн амын дунд ундны усны нөлөөнөөс хамаарах өвчлөлт тохиолддог.

Говьсүмбэр аймгийн геологийн нөхцөл нь структур тектоникийн хувьд түрүү каледоны геосинклиналь мужид багтах Дундговийн өргөгдөл, протерзойн геосинклиналь мужид үүссэн Чойрын грабен хотгорыг дүүргэсэн мезозойн формацийн бүсэд хамаарна.

Геоморфологийн хувьд зөөгдөл-хуримтлалын үйл ажиллагаа голлоно. Аймгийн хэмжээнд далайн түвшнээс дээш 1100-1300м өргөгдсөн харьцах өндөр багатай толгод, гүвээ болон хэдэн арван метрээс үл хэтрэх гүнтэй хотгор, хонхорууд бүхий талархаг рельефд хамаарагдана.

Сумын хэмжээнд цөл, цөлөрхөг хээр ба хуурай хээрийн бүсэд хамаарагдах ба жилийн турш байнга устай байдаг тоотой хэдэн нуураас өөр гадаргын усны сүлжээ байхгүй юм. Хаврын шар ус, зуны борооны үеэр түр зуурын урсгал ус үүсч улмаар ширгэж алга болдог байна.

Шивээ-Овоогийн уурхайн шүүрүүлгийн уснаас бий болсон Шивээгийн нуур бух, сугас загас үржиж байна. Уурхай жилд 4 сая шоо метр усыг газрын гүнээс татаж төмөр хоолойгоор нууранд цутгаж байна.

1.2.3. Гидрогеологийн нөхцөл:

Шивээговь сумын хувьд газар доорхи ус агуулсан хурдсуудыг нэрлэвэл:

1. Дөрөвдөгчийн хурдасны уст комплекс
2. Доод цэрдийн хурдасны уст комплекс
3. Дээд юра доод цэрдийн хагарлын бүсийн ус
4. Палеозой, мезозойн гүний чулуулгийн өгөршлийн бүсийн уст

давхарга зэрэг болно.

Ус агуулагч чулуулаг нь муу барьцалдсан элсэн чулуу, нүүрс, алевролит, хааяа хөрзөн чулуулгууд болох бөгөөд усжилттай хурдас нь 0.00-29.04м гүнд ажиглагдсан байна.

1991 онд Шивээ-Овоогийн районы газар доорхи ордод урьдчилсан нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэжээ. Уг судалгаагаар Чойрын хотгорын хойд хагаст доод цэрдийн Тэвшийн говийн свитийн хурдсанд агуулагдах газар доорхи усны ордыг илрүүлсэн байна. Судалгааны явцад 49 цооног өрөмдөж 6 туршилтын багц, 1 туршилтын ганцаарчилсан, 20 сорилтын шавхалтын ажил хийж, ордын ашиглалтын нөөцийг гидродинамик, балансын аргуудаар тооцсон байна.

Үүнд: Үйлдвэрлэлийн зэрэглэлээр үнэлсэн 14408.4м³/хон нөөцөөс А зэрэглэлээр 432.0м³/хон, В-ээр 7516.8 м³/хон тус тус эзэлж байна.

1993 онд Шивээ-Овоо, Халзан уул, Эрээний туурийн зарим хэсэгт мөн усан хангамжийн зорилгоор судалгаа явуулжээ.

1995-1998 онд Япон улсын Konoike construction Co.LTD байгуулгаас 2 цооногт гидрогеологийн туршилтын шавхалт хийж, ашиглалтын 4 цооногт туршилтын үед усны түвшинг хэмжих ажиглалт явуулсан дүнгээ үндэслэн шүүрүүлэх 27 цооногийн А ба В гэсэн 2 шугамаар өрөмдөх зөвлөмж өгсний дагуу энэхүү 2 шугамын цооногуудад өнөө үед уурхайн ус шүүрүүлэлтийн асуудлыг шийдвэрлэж байгаа болно.

2003-2004 онд ус ордод геологийн тогтоц, гидрогеологийн нөхцлийг тодотгох урьдчилсан судалгааг явуулсан байна. Тус судалгаагаар Шивээ-Овоогийн районы газар доорхи усны тэжээгдлийн бүс Чойр, Сансар уулс орчим болж байгаа бөгөөд урсгалын чиг нь хуурай сайрын ёроол хөндийг бүрдүүлж буй сэвсгэр хурдас, түүний доорхи өгөршил, тектоникийн хагарал дамжсан шинжтэй хуримтлал хөлийн бүс нь сарнисан байдлаар Шинэ усны хонхор, Сэвсүүл нуур, Мөнхийн цагаан нуур, Хар нуур, Шорвогийн тойром зэрэг нуур, тойром хонхорын зах орчимд илэрч байгааг тогтоон Шинэ усны хонхор нь тэжээлийн бүсээс урсан ирж буй газрын доорхи усны хуримтлал, хөлийн бүс болохын зэрэгцээ Нялга, Чойрын орчимд хуримтлагдаж буй усны хөлийн бүс болж байгааг баталжээ.

Шивээ-Овоогийн уурхайн ёроолд шүүрч буй усыг зүфпанд хуримтлуулж шавхан зайлуулж байна. Ийм аргаар жилд 3-4 сая м³ усыг шавхан шүүрүүлж байгаа болно.

1.2.4. Уур амьсгалын нөхцөл

Иймээс хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл бага, жилийн хур тунадасны хуваарь адил, агаарын хуурайшилт ихтэй, урт хүйтэн өвөл

болдог онцлогтой. Жилийн цэлмэг өдрийн тоо 100 хоног, хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 120 хоног байдаг.

Олон жилийн дундажаар жилийн агаарын дундаж температур -20 ба дулааны улиралд буюу VII-сард +20.30, хүйтний дундаж температур 1-р сард – 12.80 байдаг.

Хүснэгт 1. Сар, жилийн агаарын дундаж температур, °C

Станцын нэр /Чойр/	С а р у у д												Дундаж
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Шивээговь	-12.8	-16.2	-8.4	1.6	9.3	16.4	20.3	16.5	9.8	1.6	-10.2	-17.5	0.3

Хур тунадас жилд дундажаар дулааны улиралд 200.0 мм, хүйтний улиралд 15.9 мм бөгөөд V-VIII саруудад хур борооны хэлбэрээр унадаг, салхины хурд 5-9 м/сек, зарим үед 15-20 м/сек хүртэл ширүүснэ.

Хүснэгт 2. Сар, жилийн хур тунадасны нийлбэр, мм

Станцын нэр /Чойр/	Хоногийн хамгийн дулаан цагийн харьцангуй чийгшил		Хур тунадас					
	Халуун сар	Хүйтэн сар	Жил	Дулаан үе	Хоногийн хамгийн их	Он	Сар	Өдөр
Шивээговь	54	66	200.0	187.8	46.9	1948	VII	17

Салхины хурдны дундаж хэмжээг сараар гаргав. Олон жилийн судалгаанаас харахад 4,5,6 саруудад салхины хурд хамгийн их байдаг байна.

1980 оноос хойш гарсан мэдээнээс харахад 1998 оны 4 дүгээр сард 30-35м/сек хүртэл хамгийн хүчтэй шуурч байжээ. 2000 оноос хойш ихэнхидээ 4 дүгээр сард 5-6 удаа хүчтэй шуурч байсан болох нь уур амьсгалын мэдээнээс харагдана.

Хүснэгт 3. Салхины дундаж хурд м/сек

Станцын нэр /Чойр/	С а р у у д												Өвөл	Дундаж
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII		
Шивээговь	2.7	2.8	3.4	4.4	4.2	3.6	3.0	2.8	3.1	3.0	2.8	2.7	2.7	3.2

Энэ суманд голдуу хөндийн салхины гол давтагдал илэрдэг. Тухайлбал жилийн дундаж салхи баруунаас, баруун хойноос зонхилох ба нийт салхилах салхины 40-50 хувь хойноос, 10-20 хувь нь баруун хойноос, үлдсэн нь урд ба бусад зүгээс чиглэсэн салхины давтагдалтай.

Шороон шуурга хаврын улиралд их тохиолддог учир тоос шороо, агаарын тоосжил ихтэй болдог. Сүүлийн жилүүдэд шороон шуургатай өдрийн тоо өссөн ба 4, 5, 9 дүгээр саруудад хамгийн их тохиолдсон байна.

1.2.5. Хөрс, хөрсөн бүрхэвч

Сумын хөрсөн бүрхэвчийн хувьд манай оронд хамгийн өргөн тархсан элсэнцэр ба шавранцар цайвар хүрэн, хүрэн хөрс нэлээд тархана.

Ийнхүү судалгаа явуулсан бэлчээрийн газарт голдуу элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй цайвар хүрэн хөрс зонхилж байснаас гадна өндөр уулын бүдүүн ялзмагт, уулын сул хөгжилтэй хөрс, хар хүрэн хөрс, нугын хөрсний хэв шинжид нугын марзлаг, мараат, нуга-намгийн хөрстэй хам нэгдэл үүсгэж багахан газрыг эзэлж байна.

Хөрсний үржил шим, шинж төлөв, төрөл, тархалт нь газар тариалан хадлан бэлчээр мал аж ахуй эрхлэх байршуулах үндсэн хүчин зүйл болдог.

1.2.6. Ургамалжилт

Шивээговь сумын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн мужийн Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна. /Н.Өлзийхутаг, А.А.Юнатов /

Нутгийн баруун ба баруун урд хэсэгт ихэнхдээ хялгана, хазаар, харгана зэрэг ургамал зонхилсон, нам хотос тааралдах бөгөөд хуурай хээрийн тал хөндийнүүд хосолсон ухаа, гүвээ толгодууд дайралдана.

Нутгийн зүүн, урд талаараа 1400-1450 м өндөрлөгтэй Их уул, Лүн уул зэрэг бэсрэг уулсууд тааралдана.

Энд хялгана, ботууль, хиаг, ерхөг зэрэг үет ургамал, агь, навтуул, шарилж, таана зэрэг алаг өвс зонхилно.

Ус чийг дутагдалтай талхлагдсан газраар шарилж, хамхуул, лууль, агь зэрэг хуурай нөхцөлд тэсвэртэй ургамлууд нилээд тохиолдоно.

Уулын эх чулуулагтай нам уулсаар хээрийн ургамалжил нилээд түрэн ургадаг бөгөөд энд шивээт хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар өвс, агь, үхэр ба нарийн навчит харгана ургана.

Бэсрэг ба нам уулархаг газруудаараа хялгана-хазаар өвст, хазаар-хялганат, үетэн-агь-шавагт төрөл тархана. Мөн сумын төв Бүдүүн Ухаагийн баруун хөндийгөөр хялгана-хазаар-шарилжит, шарилж-хялганат, хялгана-үетэн-агьт, талхлагдсан бэлчээрийн төрөл тохиолдоно.

Нугын нам хотсын давсархаг нугаар Цагаан толгой, Шинэ усны худаг орчмын газраар гялгар дэрс, мөлхөө хиаг, монгол улаан толгой, ширэг улалж, зэрлэг арвай, галуун гичгэнэ, таван салаа зэрэг ургамлууд ургана.

1.2.7. Ан амьтан

Шивээгийн нууранд бух, сугас загас нутагшуулсан байдаг. Нуурын загасны нутагшилттай холбоотойгоор цагаан халбагант, хар өрөвтас, хөх дэглий, отгот шунгуур, халтан шунгуур, ухаа шунгуур, эгэл хараалай, буурал хараалай, бахим амуулай, цагаан дэвлээ, үхэр цахлай зэрэг 11 зүйл загас идэштэй шувууд тус нууранд зусаж, үржиж, нүүдлийн үедээ бүртгэгдэж байна.

Сумын хэмжээгээр цагаан зээр, мануул мий, шар үнэг, хярс үнэг, халздай дорго, боролзон туулай, дагуур оргодой, сүүлэрхэг зурам, шивэр алаг даага, сохор номин зэрэг амьтад нийт нутгаар тархсан байна.

1.2.8. Орчны бохирдол

Тус сумын хэмжээнд хуучнаар ЗХУ-ын зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн ашиглаж байгаад орхигдсон барилга, байгууламжийг нурааснаар барилгын туурь, хатуу хог хаягдал ихээр хуримтлагдан орчныг бохирдуулж, газрын гадаргын элэгдэл, эвдрэлийг бий болгож, газар ашиглалтад сөргөөр нөлөөлсөөр байна.

Малын сэг зэм, авто зам дагууд нилээдгүй тааралдаж байгаа нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөр байна. Мөн ан амьтад, шувууд малын сэг, зэмээр хооллохдоо авто машинд дайрагдаж эндэх зэргээр хохирол учруулж байна.

1.3. Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл


1.3.1. Хүн ам

Хүн амын тоо: 2010 оны тоогоор тус сумын нийт хүн амын тоо 2947 үүний эрэгтэй 1500, эмэгтэй 1447 байсан бөгөөд 2016 онд хүн амын тоо 3378 үүнээс эрэгтэй 1633, эмэгтэй 1621 тоологдсон байна.


Хүснэгт 4. Хүн амын тоон өөрчлөлт

Он	Эрэгтэй	Эмэгтэй	Шивээговь сум
2010	1500	1447	2947
2011	1543	1480	3023
2012	1530	1470	3000
2013	1571	1505	3076
2014	1628	1570	3198
2015	1686	1568	3254
2016	1633	1621	3378

Бүдүүвч 1. Шивээ-говь сумын хүн ам, өрхийн тооны өөрчлөлт, 2010-2016 он




Бүдүүвч 2. Суурин байгаа хүн амын тоо: 2016он



Насны бүтэц: 2016 оны байдлаар Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумын 3378 хүн амын 48.3 хувь нь эрэгтэй, 47.9 хувь нь эмэгтэй хүн ам байна.

Нийт хүн амын 33.1 хувийг 0-15 насны хүүхэд, 55.9 хувийг 16-59 насны хүмүүс, 3.7 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 84, 80 ба түүнээс дээш настан 19, 90 ба түүнээс дээш настан 2 тоологдсон байна. Бүдүүвч 3.



Ажил эрхлэлт: 2016 онд хөдөлмөрийн насны хүн ам 2043, үүнээс 1291 нь ажиллагчид байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 63.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. Ажиллагчидын тоо, 2010-2016 он


	Шивээ-говь	Говьсүмбэр
2010	966	4566
2011	978	4641
2012	995	4799
2013	988	5047
2014	981	5238
2015	1286	5827
2016	1291	5988

Эх сурвалж: Шивээ-говь сумын хүн ам, нийгмийн үзүүлэлт, 2003-2016 он

Шилжих хөдөлгөөн: 2010-2016 оны хугацаанд шилжин ирэгчдийн тоо Говьсүмбэр аймгийн хэмжээнд 5491 Шивээ-говь сумын хэмжээнд 1006 хүн амын тоо бүртгэгдсэн байна.

2010-2016 оны хугацаанд шилжин явсан хүний тоо Говьсүмбэр аймгийн хэмжээнд 4734 Шивээ-говь сумын хэмжээнд 921 хүн амын тоо бүртгэгдсэн байна.

Бүдүүвч 4. Шивээ-говь сум шилжих хөдөлгөөн, 2010-2016 он



Хүснэгт 6. Шилжих хөдөлгөөн

Он	Шилжин ирсэн	Шилжин явсан
	Шивээ-говь сум	Шивээ-говь сум
2010	188	148
2011	156	163
2012	112	113
2013	135	144
2014	157	108
2015	132	144
2016	126	101

1.3.2. Газар тариалан

2016 онд 8.8 га талбайд тариалалт хийснээс төмс 3.41 га-д, хүнсний ногоо 5.36 га-д тариалсан байна.

Төмс хүнсний ногоог өрхийн үйлдвэрлэлийн хэмжээнд тариалах ажил сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаагаас орон нутгийн хүнсний хэрэгцээний тодорхой хэсгийг хангаж байна. 2016 онд төмс болон хүнсний ногооны тариалалтын га болон ургац хураан авах хэмжээ нэмэгджээ.

Хүснэгт 7. 2016 оны тариалалт, ургац хураалт

№	Сумдын нэр	Тариалалт				Ургац хураалт			
		Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Жимс жимсгэнэ	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Жимс жимсгэнэ

1	Шивээ-ГОВЬ СУМ	3.41	5.36	-	-	25.76	72.53	-	-
Нийт дүн									


Хүснэгт 8. Тариалсан талбай /га/

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-ГОВЬ сум	11.0	11.6	10.6	13.1	7.1	8.0	8.8

Хүснэгт 9. Хураасан ургац /га/

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-ГОВЬ сум	18.7	103.6	31.0	43.9	35.5	75.7	86.4

Бүдүүвч 5. Тариалсан талбай, ургац хураалт



1.2.3. Мал аж ахуй

2010 онд Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумын хэмжээнд 70 өрхийн 122 малчин байсан бол 2016 онд 92 малчин өрхийн 150 малчин бүртгэгдсэн байна. Малчидын тоо 2016 онд 2010 оноос 34.4 хувиар буюу 28-аар өссөн байна. 2016 оны жилийн эцсээр Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сум 295,3 мянган толгой малтай болсон нь 2015 оны мөн үеэс 18.4 мянган толгой буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 1520 толгой, үхэр 1581 толгой, тэмээ 92 толгой, хонь 19288 толгой, ямаа 21229 толгой тус тус тоологджээ.

Хүснэгт 10. Малын тоо, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-ГОВЬ сум	20516	23048	26320	31868	40892	42710	43428

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2009-2015 он

Хүснэгт 11. Малчин өрхийн тоо, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-ГОВЬ сум	70	81	69	70	86	91	92

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2009-2015 он

Хүснэгт 12. Малчидын тоо, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-ГОВЬ сум	122	134	109	110	136	142	150

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2009-2015 он

Хүснэгт 13. Том малын зүй бус хорогдол, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-ГОВЬ сум	2073	28	31	29	97	204	3555

Энэ онд тус аймагт нэг мянгаас дээш толгой мал тоолуулсан 90 малтай иргэн бүртгэгдсэнээс 88 нь малчин байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 буюу 6.4 хувиар буурлаа. Үүнд:

Шивээговь сумын мянгат малчин -10 байна.

Сумын хүн амын хүнсний хэрэгцээний тодорхой хэсгийг хангах зорилгоор гахай тахианы аж ахуйг хувь иргэн эрхлэн явуулж байна.

Хүснэгт 14. Тэжээвэр амьтад

	Гахай:				Тахиа:			
	Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад	Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад
Шивээ-ГОВЬ сум	21	5	3	13	11	10	1	0

1.2.4. Аж үйлдвэр

Тээвэр: Дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн. Тус аймгийн нутгаар Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон Транс Сибирийн олон улсын транзит төмөр зам, агаарын коридор дайран өнгөрдөг.

Эрчим хүч: Цахилгаан эрчим хүчний дамжуулах станц нь Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгуудын 19 төв суурин газар, сумд, эдгээр сумын нутагт орших үйлдвэрийн газрууд, айл өрхийг цахилгаан эрчим хүчээр ханган ажилладаг. Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон, тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан, дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломж бүрдсэн.

Аж үйлдвэржилт: Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сум нь сүүлийн жилүүдэд эдийн засгийн хувьд эрчимтэй өсөж байгаа бөгөөд томоохон үйлдвэрүүдээс дурьдвал нүүрсний уурхай, жонш угаах үйлдвэр, үйлдвэрүүд тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Улсын хэмжээний томоохон уурхайн нэг болох Шивээ-Овоогийн нүүрсний уурхайтай. Тус уурхай нь одоогийн байдлаар улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 30 хувийг хангадаг. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг “Шивээ-Овоо” ХК, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ, “зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг бөгөөд эдгээр аж ахуйн нэгж байгууллагууд 2016 онд 47.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 44.7 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

2015 оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 25.3 хувиар өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлсөн байна. Бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өслөө. “Шивээ-Овоо” ХК нь тайлант онд 45.1 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэж, 42.8 тэр бум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 26.4 хувиар, бүтээгдэхүүн борлуулалт 15.0 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Тус компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 95.9 хувийг, нийт борлуулалтын 95.6 хувийг гүйцэтгэсэн бөгөөд зах зээл дээр 1 тонн нүүрсийг 26642 төгрөгөөр худалдаалж байна.

1.2.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ

Шивээ-Овоо ХК: Монгол Улсын Засгийн газраас тус уурхайг хувьчлах шийдвэр гаргасны дагуу 1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр “Шивээ-Овоо”

хувьцаат компанийг байгуулсан. Компанийн нийт дүрмийн сангийн 90 хувийг төр, 10 хувийг хувьцаа нийлүүлэгчид эзэмшдэг.

“Шивээ Овоо” ХК нь одоо 450 гаруй ажиллагсадтай, жилдээ 1.5-2.0 сая тонн нүүрс олборлож жилдээ 4.6 сая шоометр хөрс хуулж, хүчин чадал нь анхныхаасаа 4 дахин нэмэгдэж сүүлийн 5н жилд 37.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж улсын төсөвт 6.0 тэрбум төгрөг төлж Говьсүмбэр аймгийн төсвийн 87 хувийг хангадаг. Нүүрсний олборлолт, борлуулалтын хэмжээгээр Багануурын уурхайн дараа хоёрдугаарт ордог .

“Говь-гео” ХХК: Говь-гео ХХКомпани нь үндсэн чиглэл нүүрс олборлолт бөгөөд хайлуур жоншны үйлвэрлэл эрхэлж, хайгуулын өрөмдлөг болон зочид буудал, супермаркет, ресторан гэсэн үндсэн 5 нэгжтэйгээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байна.

Илчлэг-Шивээ орон нутгийн өмчит үйлдвэрийн газар: 1999 онд Говьсүмбэр аймгийн Засаг даргын захирамжаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж улсын бүртгэлийн гэрчилгээ олгож үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Одоогоор тус байгууллага нь дулаан, ус хангамжийн байгууллага болон өргөжиж сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд дулаан, цэвэр усны үйлчилгээ үзүүлж жилдээ 100 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж байна.

1.2.6. Дэд бүтэц, зам харилцаа, бусад салбар

Одоогийн байдлаар тус сумын төвийн ихэнх хэсэг нь төвлөрсөн нам даралтын 2 халаалтын зуухнаас дулаан авч байгаа ба үлдсэн хэрэглэгчид нь өөр өөрийн халаалтын жижиг зуухтай.

Халаалтын зуухны түлшинд 17 км зайтай орших Шивээ-Овоогийн уурхайн нүүрсийг хэрэглэж байна. Дулаан гаргах доод чадвар нь: 3100 ккал/кг.

1.2.7. Боловсрол

2015-2016 оны хичээлийн жилд удирдах ажилтан 4, багш 34, үйлчилгээний ажилтан 14, бүгд 52 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэй, 12 жилийн статустайгаар үйл ажиллагаагаа явуулж, нийт 597 сурагч суралцаж байна.


Хоёрдугаар бүлэг. СУМЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН БҮТЭЦ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

2.1. Сумын газрын нэгдмэл сангийн бүтэц

2016 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумын Газрын нэгдмэл санд: Хүснэгт 15.

Газрын нэгдмэл сангийн ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	81947.97	95.5
Хот, тосгон бусад суурины газар	2003.02	2.33
Зам, шугам сүлжээний газар	997.31	1.16
Усны сан бүхий газар	806.7	0.94
Улсын тусгай хэрэгцээний газар	0	0

Бүдүүвч 6. Газрын нэгдмэл сангийн ангилал



2.1.1. Хөдөө аж ахуйн ангиллын газрын бүтэц, ашиглалт, хамгаалалтын байдал

Хөдөө аж ахуйн газар нь нэгдмэл сангийн нийт нутаг дэвсгэрийн 81947.97 га буюу 95.5 хувийг эзэлж байна. Хүснэгт 16. Үүнд:

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Бэлчээрийн газар	81843.72	99.8
Хадлангийн талбай	0	0
Тариалангийн газар	70.5	0.08
Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн	33.75	0.04

дэвсгэр газар		
Хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар	0	0

Бүдүүвч 7. Хөдөө аж ахуйн ангиллын газрын бүтэц



Тариалангийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

2016 онд 8.8 га талбайд тариалалт хийснээс төмс 3.41 га-д, хүнсний ногоо 5.36 га-д тариалсан байна. Шивээговь сумын 2-р багийн Шивээгийн булаг гэдэг газарт аймгийн ХААГазрын “Сувгийн услалтын систем”-ыг 2014 онд ашиглалтад оруулан 5.4 га талбайд төмс, хүнсний ногоо, малын тэжээл тариалж байна. Мөн тайлант онд “Шивээ-овоо” ХХК дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр 2 га-д тариалж 4000 ширхэг чацарганы суулгац суулгасан байна.

Тариалсан талбай /га/

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Шивээ-говь сум	11.0	11.6	10.6	13.1	7.1	8.0	8.8

ХАА-н барилга байгууламжийн газар

Өвөлжөө, хаваржаа: Тус аймагт нийт 1231 малчин өрхийн 376 өвөлжөө, хаваржаа байгаа бөгөөд Шивээговь суманд 74 өвөлжөө бууц байна.

Худаг: 2017 оны байдлаар аймгийн хэмжээнд тоологдсон нийт 7796 худаг байгаагаас Шивээговь суманд 92 худаг байршиж байна. Хүснэгт 17.

№	Сумын нэр	Худгийн тоо		
		Өрөмдмөл	Гар худаг	Нийт
1	Шивээговь	45	47	92

ДҮН	45	47	92
-----	----	----	----

Услалтын систем: Сумын хэмжээнд Шивээгийн булгийн сувгийн услалтын систем байдаг. “Шивээгийн булаг”-ийн 5.4 га ашигтай талбай бүхий сувгийн услалтын системийг уурхайн гүний хаягдал усыг түшиглэн 2013 оны 10 сард ашиглалтад оруулсан. 2016 оны байдлаар талбайн ашиглалт 16.8 хувьтай байна.

Зоорь: Суманд 109.5 тн-ийн багтаамжтай төмс, хүнсний ногооны холимог зоорь 6-г ашиглаж байна.

Бэлчээрийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Газрын нэгдмэл сангийн ангиллын 2016 оны тайланд тус сумын бэлчээрийн газар нийт 81843.72 га талбай ба 99.8 хувийг эзэлж байгаа бөгөөд урьд оноос 134.88 га-р хасагдсан байна.

Бэлчээрийн газрыг зун-намрын, өвөл-хаврын гэсэн ерөнхий хуваарьтай ашигладаг байна. Одоогоор ихэнх малчид отор нүүдэл хийхгүй нэг буйран дээрээ жилийн дөрвөн улиралд суурин байж, бэлчээрийг давтан ашигласнаар бэлчээр талхагдаж доройтон муудсаар байна.

Харин Сэвхүүлийн улаан нуур, Бэхтийн улаан нуур, Эрээн сумын туур, Мөнхтийн нуур, Тогоо булаг нутгуудаар малыг ихээхэн бөөгнөрүүлснээс хөрсөн бүрхэвч нь тоосорхог болж бэлчээр талхлагдан ургамалшилт нь ихээхэн өөрчлөлтөнд оржээ.

Бэсрэг ба нам уулс, хуурай хээрийн бэлчээр нь мал аж ахуйг эрхлэхэд таатай боловч бэлчээрийг хуваарь сэлгээгүй ашигласнаас намаржаа, хаваржаа, зуслангийн ойролцоох бэлчээр ихээхэн талхлагдаж байна.

Хүснэгт 18. Шивээговь сумын бэлчээрийн даац /улирал/

№	Бэлчээр	Талбайн хэмжээ	1 га ургалын хэмжээ цн/га	Бэлчээрийн нөөц цн/га	1 хонины жилд идэх өвсний хэмжээ /цн	Бэлчээрийн багтаамж/хонин тол	Бэлчээрт байгаа малын тоо	Бэлчээрийн даац хэтэрсэн эсэх + %
1	Бэлчээрийн нийт талбай	82472.0	1.2	98966.4	5.6	17673	58788.2	-3.3
2	Өвөл-хаврын бэлчээр	40603	0.7	28422.1	1.1	25838	58788.2	-2.3
3	Зун-намрын бэлчээр	41869	1.1	46055.9	1.5	30703.9	58788.2	-1.9

Шивээговь сумын бэлчээрийн даац дунджаар 3.3 дахин хэтэрсэн ба үүнээс өвөл, хаврын улиралд 2.3 дахин, зун, намрын улиралд 1.9 дахин даацыг хэтрүүлэн ашиглаж байна.

Мөн түүнчлэн урьд ашиглагдаж байсан худгууд эвдэрч тоногдсон учир одоо ашиглаж байгаа цөөхөн худгаа бараадан айлууд бөөгнөрөн бууснаас бэлчээр талхлагдах нэгэн хүчин зүйл болж байна.


Иймээс бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг сайжруулах, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл нь бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, талхлагдсан бэлчээрийн сэргээх, даацад тохируулан бэлчээр нутгаа ашиглах, малын тоо толгойг цөөрүүлэн малын чанарт анхааран малын үүлдэр угсааг сайжруулах зэрэг асуудал юм.

2.1.2. Хот, тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал

Хот, тосгон бусад суурины газар нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн **2003.02** га буюу **2.33** хувийг эзэлж байна. Хүснэгт 19. Үүнд:

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Барилга байгууламжийн дэвсгэр газар	259.55	12.95
Нийтийн эдэлбэр газар	961.00	47.97
Үйлдвэрийн газар	103.45	5.16
Уурхайн газар	476	23.7
Гэр хорооллын газар	203.02	10.1

Бүдүүвч 8. Хот, тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц



Барилга, байгууламжийн дэвсгэр газар нийт 259.55 га бөгөөд 12.95 хувь, нийтийн эдэлбэрийн газрын хэмжээ 961.00 га ба 47.97 хувь, үйлдвэрийн газар 103.45 га ба 5.16 хувь, уурхайн газар 476 га ба 23.7 хувь, гэр хорооллын газрын нийт хэмжээ 203.02 га ба 110.1 хувийг тус тус эзэлж байна.

Амралт, рашаан сувиллын газрын ашиглалтын одоогийн байдал

Аялал жуулчлал:

Шивээ-Овоогийн уурхайн шүүрүүлгийн уснаас бий болсон Шивээгийн булгийн нууранд бух, сугас загас үржиж байна. Энэ нуурыг түшиглэн жуулчны бааз шинээр баригдаж, үйл ажиллагаагаа явуулахад бэлэн болсон байлаа.



Үйлдвэр уурхайн газрын ашиглалт, хамгаалалтын байдал

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг Шивээ овоо нүүрсний уурхай нь 475.8 га талбайг эзэлдэг байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг эзэлдэг 564090 мян.тн-н нөөцтөй Шивээ-овоогийн нүүрсний уурхай нь тус аймгийн Шивээговь сумын нутагт оршиж “Шивээ-овоо”ТӨХК үйл ажиллагаа явуулж байна. Шивээ-Овоогийн нүүрсний орд нь нийт 29500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2708.7 сая тн нүүрсний нөөцтэй, 3 үндсэн хэсгээс бүрдэж байна.


2.1.3. Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалт

Зам, шугам сүлжээний газар нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 997.31 га буюу 1.16 хувийг эзэлж байна.

Үүнд: Авто замын газар 165.55 га буюу 16.5 хувь, шугам, сүлжээний газар 558.04 га 55.9 хувь, төмөр замын газар 258.72 га буюу 25.9 хувийг тус тус эзэлж байна. Хүснэгт 20. Үүнд:

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Авто замын газар	165.55	16.5
Шугам сүлжээний газар	558.04	55.9
Төмөр замын газар	258.72	25.9

Бүдүүвч 9. Зам, шугам сүлжээний ангиллын газрын бүтэц



Аймгийн хэмжээнд төмөр замын нийт 1358.99 га газраас төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар 1088.77 га-г, өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн талбай 270.22 га-г тус тус эзэлж байгаас Шивээговь суманд 258.75 га талбайг буюу нийт нутаг дэвсгэрийнхээ 25.9 хувийг эзэлж байна.

Инженерийн шугам сүлжээний зурвас газар

Говьсүмбэр аймагт шугам сүлжээний дэд ангилалд хамаарах 558.04 га газар байгаа бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 55.9 хувийг эзэлж байна. Цэвэр ус дамжуулах хоолой нь 5 га газрыг эзэлдэг. Эдгээр шугам нь Хэнтий аймгийн Өндөрхааны дэд станцаас гарч Сүмбэр, Баянтал сумын нутгаар дайрч Чойрын дэд станц дээр ирээд Шивээ-Овоогийн уурхай болон Шивээговь сум, Дорноговь аймгийн Далантүрүү мөн Дундговь аймгийн Говьугтаал сумруу салбарлан явсан цахилгааны шугамнууд хамаарна.


Эдгээр шугам сүлжээний газрууд нь эрчим хүчний шугамын зурвас газар болон холбооны шугамын зурвас газар нэрээр бүртгэгдэж байдаг боловч бэлчээрийн газарт ашиглагдаж байдаг онцлогтой.

2.1.5. Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Усан сан бүхий газар нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 806.7 га буюу 0.94 хувийг эзэлж байна. Үүнд: гол, мөрний газар 4.2 га буюу хувь, нуур цөөрмийн эзлэх талбай 802.5 га хувийг тус тус эзэлж байна. Хүснэгт 21.

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Гол, мөрний газар	4.2	0.5
Нуур цөөрмийн газар	802.5	99.4

Бүдүүвч 10. Усны сангийн ангиллын газрын бүтэц



2.1.6. Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

Тус суманд орон нутгийн тусгай хамгаалалтад авсан нийт 931.56 га газар байна.

Бэхтийн булгийг сумын ИТХ-ын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 05 тоот тогтоолоор 60 жилийн хугацаатай, байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, ундаргыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.

Хүснэгт 22. Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрууд

д/д	Орон нутгийн хамгаалалтад авах газрууд	Хамгаалах зүйл	Талбайн хэмжээ
1	Бэхтийн булаг	Байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, ундаргыг нэмэгдүүлэх	931.56

Гуравдугаар бүлэг. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ


3.1. Хүн амын өсөлтийн хэтийн төлөв

Сум орон нутгийн цаашдын хөгжил нь оршин суугаа хүн амаас шууд хамааралтай байдаг. Иймд Шивээговь сумын нийт хүн амын өсөлтийн хэтийн төлөвийг ердийн болон нийгмийн өөрчлөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, төрөлт нас баралт, ажиллах хүчний тоо, нэн шаардлагатай байгаа ажлын байрны тоо зэрэгтэй уялдуулан нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгжих 5 жилийн буюу 2018-2022 он хүртэлх хугацаанд тооцож гаргав.

2022 оны түвшинд Шивээговь сумын хүн ам 4324 орчим хүн амтай болж өсөх ба 1240 орчим өрхтэй болох тооцоог гаргасан.

Хүснэгт 23. Шивээговь сумын хүн амын хэтийн өсөлт /хүйсээр/

Сумы нэр	Хүйс	2018	2019	2020	2021	2022
Шивээговь	Нийт	3628	3895	3993	4123	4324
	Эр	2017	2263	2245	2449	2269
	Эм	1611	1632	1653	1674	1695



2016 онд нийт хүн ам 3378 байснаас эрэгтэй 1745, эмэгтэй 1633 хүнтэй байна. Нийт хүн амын 51.6 хувийг эрэгтэйчүүд, 48.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Харин төлөвлөлтийн хугацаанд 2018 он гэхэд нийт хүн ам 3628, 2019 он гэхэд 3895, 2020 он гэхэд 3993, 2021 онд 4123, 2022 онд 4324 хүн амтай болж өсөх төлөвтэй байна.

3.2. Өрхийн тооны хэтийн өсөлт

Тус аймгийн өрхийн тоо 2018 оны түвшинд 5522 өрх, 2019 онд 5689 өрх, 2020 онд 5856 өрх, 2021 онд 6023 өрх, 2022 онд 6190 өрх болж өсөх хандлагатай байна. Үүнээс Шивээговь суманд 2018 онд 1124, 2019 онд 1153, 2020 онд 1182, 2021 онд 1211, 2022 онд 1240 өрхтэй болох тооцоог хийлээ.

Хүснэгт 24. Өрхийн хэтийн төлөв

	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Говьсүмбэр	5522	5689	5856	6023	6190
Шивээговь	1124	1153	1182	1211	1240

Дөрөвдүгээр бүлэг. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭРЭГЦЭЭТ БАЙДАЛ

Тус сумын хүн амын хүнсний хэрэгцээ нь орон нутгийн хөгжлийн өсөлтөд нөлөө үзүүлдэг байна.

Хүн амыг насны бүлэг, эрхэлж байгаа ажил төрөл, эрэгтэй, эмэгтэй хүйсийн байдлаар нь бүлэглэж нэгж хүнд хоногт шаардагдах калорийн хэмжээг тогтоосон нормоор тооцож үзэхэд Шивээговь сумын нэг хүнд хоногт дунджаар 2517.4 калори бүхий хүнс, тэжээл хэрэглэх шаардлагатай байна. Үүнийг хангахад 10 хувийн нэмэгдэл нөөцтэй байх нь зүйтэй гэж үзвэл 2864.5 калорийн илчлэг өгөх хүнсний нөөцтэй байх хэрэгцээ гарна.

Хүснэгт 25. Нэг хүнд шаардагдах хүнсний илчлэгийн хэмжээ

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	1 хүний хэрэгцээний норм		Хоногт оногдох шимт бодис, илчлэг			
		Хоногт /гр/	Жилд /кг/	Уураг	Өөх тос	Нүүрс ус	Илчлэг
1	Сүү-сүүн бүтээгдэхүүн	233	85.0	23.80	34.30	30.80	542.85
2	Цөцгийн тос	20	7.3	-	19.01	-	176.83
3	Мах, махан бүтээгдэхүүн	374	136.5	28.42	38.70	-	476.44
4	Өндөг	30	11.0	11.83	1.42	-	61.72
5	Загас-загасан бүтээгдэхүүн	4.4	1.6	0.40	0.28	-	4.24
6	Ургамлын тос	225	82.1	0.03	4.93	-	45.95
7	Гурил-Гурилан бүтээгдэхүүн	770	281.1	32.17	2.23	230.13	1096.20
8	Будаа	269	98.2	2.25	0.29	23.02	105.92
9	Төмс	123	44.9	1.68	-	19.60	87.25
10	Хүнсний ногоо	28	10.2	1.71	-	5.76	30.61
11	Сахар, чихрийн зүйл	92	33.6	-	-	56.99	233.66
12	Жимс, жимсгэнэ	265	96.7	10.03	0.16	0.25	2.88
13	Буурцагт ургамал	84	30.7	1		20	
	Бүгд	2517.4	918.9	113.32	101.32	386.55	2864.55
	Калори	-	-	430.616	891.616	1542.32	2864.55

Нэг хүнд хоногт буюу жилд оногдох хүнсний бүтээгдэхүүний өсөлт нь хүн амын хүнсний хэрэгцээний өсөлтийг тодорхойлох хэмжигдэхүүн болж байна. Шивээговь сумын хүн амд шаардагдах хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг хүнсэндээ ихэвчлэн хэрэглэж буй мах, сүү, гурил гэх зэрэг 13 гол бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийг төлөвлөлтийн хугацаагаар тойдорхойллоо.

Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд анхааран орон нутгийн нөөц боломжиндоо тулгуурлан хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, өндөг, гурилан бүтээгдэхүүн хэрэглэхийн тулд нэр төрлийг нэмэгдүүлэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж сумын хүн амын болон уурхайн ажилчдын хүнсний хэрэгцээг хангах бичил үйлдвэр цехүүдийг байгуулах шаардлагатай.

Дээрх хүснэгтэд дурьдсан хүнсний зүйлийн зарим нэр төрлийн хэрэгцээг сумын дотоод нөөц бололцоогоор үйлдвэрлэх боломжтой.

Хүснэгт 26. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент		2018 он		2019 он		2020 он		2021он		2022 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/
1	Мах, махан бүтээгдэхүүн	73	5 хошуу малын мах	1	1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520
		73	Гахай шувуу загасны мах	1	1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520
2	Сүү	54.8	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү	1	1124	61595.2	1153	63184.4	1182	64773.6	1211	66362.8	1240	67952
		54.8	Уламжлалт аргаар боловсруулсан сүү	1	1124	61595.2	1153	63184.4	1182	64773.6	1211	66362.8	1240	67952
3	Сүүн бүтээгдэхүүн	73			1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520
4	Гурил	36.5	Буудайн гурил	1	1124	41026	1153	42084.5	1182	43143	1211	44201.5	1240	45260
5	Гурилан бүтээгдэхүүн	80.3	талх	0.74	1124	66790.3	1153	68513.6	1182	70236.8	1211	71960	1240	73683.3
6	Төрөл бүрийн будаа	28.5		1	1124	32034	1153	32860.5	1182	33687	1211	34513.5	1240	35340
7	Сахар, чихрийн зүйл	8.4		1	1124	9441.6	1153	9685.2	1182	9928.8	1211	10172.4	1240	10416
8	Төмс	51.1		1	1124	57436.4	1153	58918.3	1182	60400.2	1211	61882.1	1240	63364
9	Хүнсний ногоо	73		1	1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520
10	Жимс, жимсгэнэ	65.7		1	1124	73846.8	1153	75752.1	1182	77657.4	1211	79562.7	1240	81468
11	Буурцагт ургамал	32.9		1	1124	36979.6	1153	37933.7	1182	38887.8	1211	39841.9	1240	40796
12	Өндөг	6.9		1	1124	7755.6	1153	7955.7	1182	8155.8	1211	8355.9	1240	8556
13	Хүнсний тос	9.1		1	1124	10228.4	1153	10492.3	1182	10756.2	1211	11020.1	1240	11284

4.1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн хэтийн төлөв

Шивээговь сумын хүн амын хэрэгцээнд зориулж 2022 онд 45.2 тн гурил, 73.6 тн гурилан бүтээгдэхүүн, 63.3 тн төмс, 90.5 тн хүнсний ногоо бэлтгэх хэрэгцээ гарч байна. Энэ нь одоогийн орон нутгийн үйлдвэрлэлээр 25.76 тн төмс, 72.53 тн хүнсний ногоо тариалж байгааг 2022 он гэхэд төмсийг 2.4 хувиар, хүнсний ногоог 1.2 хувиар, гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг 100 хувиар тус тус нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

Хүснэгт 27. Гурил, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент		2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/
1	Гурил	36.5	Буудайн гурил	1	1124	41026	1153	42084.5	1182	43143	1211	44201.5	1240	45260
2	Гурилан бүтээгдэхүүн	80.3	талх	0.74	1124	66790	1153	68513.6	1182	70236.8	1211	71960	1240	73683.3
3	Төмс	51.1		1	1124	57436	1153	58918.3	1182	60400.2	1211	61882.1	1240	63364
4	Хүнсний ногоо	73		1	1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520
5	Жимс, жимсгэнэ	65.7		1	1124	73846.8	1153	75752.1	1182	77657.4	1211	79562.7	1240	81468

Одоогийн байдлаар тус суманд чацаргана, амтат гуа гэх зэрэг жимс, жимсгэнийг багахан хэмжээгээр тариалж байна. Цаашид хүн амыг 81.4 тн жимс, жимсгэнээр хангах тооцоо гарч байна.

4.2. Мал аж ахуйн хэтийн төлөв

Шивээговь сумын хүн амын хэрэгцээнд зориулж 2018 онд 5 хошуу малын 82.0 тн мах, 2019 онд 84.1 тн мах, 2020 онд 86.2 тн мах, 2021 онд 88.4 тн мах, 2022 онд 90.5 тн мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх хэрэгцээ гарна

Хүснэгт 28. Мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент		2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/
1	Мах, махан	73	5 хошуу малын	1	1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520

	бүтээгдэхүүн	мах											
	73	Гахай шувуу загасны мах	1	1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520

Сумын нийт малын өсөлтийг төлөвлөлтийн хугацаанд буюу 2018-2022 оны түвшинд тооцож үзэхэд 53 мянга орчим болж өсөхөөр байна. Үүнээс адуу 1708, үхэр 2277, хонь 25 мянга, ямаа 23 мянга, тэмээ 145 толгой болно. Бид ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хугацаанд малын тоотой уялдуулан бэлчээрийн даац, хүрэлцээ ямар хэмжээтэй байх тооцоог “бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө” хэсэгт оруулан тооцсон.

Хүснэгт 29. Шивээговь сумын малын өсөлтийн хэтийн төлөв

Малын төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Бүгд	46190	48504	49801	51095	53389
Адуу	1638	1670	1687	1698	1708
Үхэр	1829	1941	2053	2165	2277
Хонь	22408	23886	24365	24844	25323
Ямаа	20194	20879.5	21565	22250.5	23936
Тэмээ	121	127	131	138	145

4.3. Шивээговь сумын орон сууцны хэрэгцээ, хэтийн төлөв

Тус суманд ажиллаж амьдрах тохилог орчин бүрдүүлэх зорилгоор инженерийн нэгдсэн хангамжид холбогдсон 5 давхар 1.3 мян өрхийн нийтийн тохилог орон сууцууд төлөвлөсөн. Хаус буюу амины орон сууцны хэлбэрийг төлөвлөсөн ба энд 0.36 мян хүн ам оршин суух боломжтой мөн сууцны нийтлэг хэлбэр болох гэр сууц болон байшин сууцны хорооллыг инженерийн шийдэлтэй төлөвлөгдсөн гэрийн хороололд 0.44 өрх айл хамрагдана. Төлөвлөлтийн хугацаанд нийтийн орон сууцны хангамж 75 буюу одоогийн түвшинээс 10 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Нэг хүнд ногдох эрүүл ахуйн нормоор тооцоход 2022 оны түвшинд нийт 196214 мян.м2 талбай бүхий орон сууцанд 8.2 мян.хүн оршин сууснаар хангамж хэвийн түвшинд ойртоно. Орон сууцны барилгажилтын үе шатыг хүснэгт 4.7-д үзүүлэв.

Хүснэгт 30. Орон сууцны хэрэгцээ, хэтийн төлөв

1	Нийтийн орон сууц	Хүн	1801	4140	8250
2	Өрх	Өрх	565	1035	2200
3	Амины орон сууц	Хүн	113	700	1430
4	Өрх	Өрх	42	175	360
5	Гэр сууц	Хүн	841	1660	1320
6	Өрх	Өрх	322	300	440

Хүснэгт 31. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хэрэгцээ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоо байгаа		Шаардагдаг хүчин чадал	
			Төслийн	Бодит	Нийт	Үүнээс эхний ээлж
1	Сургууль	Сурагч	640	529	3000	960
2	Цэцэрлэг	Хүүхэд	90	190	770	150
3	Эмнэлэг	Ор	15		75	20

Тавдугаар бүлэг. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

ГХГЗЗГ-ын даргын тушаалын 2015 оны 9-р сарын 9-ний өдрийн А/200 тоот “Газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүй, шалгуур үзүүлэлтүүд батлах тухай” тушаалд зааснаар Говьсүмбэр аймгийн бэлчээр, тариалан, хот суурин, ой, зам, шугам сүлжээ болон аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг дараахь шалгуур аргачлалын дагуу хийсэн.

5.1. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ


Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Тариалангийн газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Тариаланд тохиромжтой газрын иж бүрэн үнэлгээ өгөхдөө хүрээлэн буй орчныг нэгдсэн систем гэж үзэж, байгаль болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдийг хослуулж 5 шатлалтай ангиллаар үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлт бүрт тохируулан тогтоосон онооны (баллын) аргаар үнэлгээг боловсруулна.
/Хүснэгт 32/ Үүнд:

1. Геофизик хүчин зүйлийн үнэлгээ	2. Уур амьсгалын үнэлгээ	3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ	
1.1. Газрын гадаргын үнэлгээ;	2.1. Агаарын температур;	3.1. Ой бүхий талбай;	3.6. Түүх соёлын дурсгалт газар;
1.2. Гидрологийн үнэлгээ;	2.2. Хур тунадас;	3.2. Хот суурингийн газар;	3.7. Археологийн үнэт олдвор;
1.3. Инженер-геологийн үнэлгээ;	2.3. Дулаан хангамжийн нөхцөл;	3.3. Зам, шугам сүлжээний газар;	3.8. Гол, мөрөн;
1.4. Хөрсний үнэлгээ;	2.4. Чийг хангамжийн нөхцөл;	3.4. Тариалангийн талбай;	3.9. Булаг, худаг уст цэг;
		3.5. Уул уурхайн талбай;	3.10. Манхан элс;


Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд бүдүүвч 12-т тусгагдсан нийт 3 үндсэн, 29 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэсэн.

Бүдүүвч 12. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



Хүснэгт 32. Тариалангийн газрын байдлын тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай хэмжээ	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	7821.77	8.701
Тохиромжгүй	276.25	0.307
Хязгаарлагдмал тохиромжтой	35822.38	39.8
Тохиромжтой	45967.81	51.1



5.2. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ


Байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм.

Говьсүмбэр аймгийн Ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. /хүснэгт 33/
Үүнд:

Ландшафтын үнэлгээ	2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ	3. Дэд бүтцийн үнэлгээ	4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ
1.1. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ	2.1. Байгаль-соёлын дурсгалт газар	3.1. Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)	4.1. Тариалангийн талбай
1.2. Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ	2.2. Түүх-соёлын дурсгалт газар	3.2. Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх	4.2. Одоо байгаа хот суурин газар
1.3. Гадаргын ус-рашааны аялал-рекреацийн үнэлгээ		3.3. Тохижилтын түвшин	4.3. Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
1.4. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ			4.4. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс
1.5. Ландшафтын гоо зүйн үнэлгээ			


Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ”-г боловсруулна. Байгалийн аялал-рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

Бүдүүвч 13. Ландшафтын үнэлгээний схем



Хүснэгт 33. Аялал жуулчлалын газрын байдлын тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай хэмжээ	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	8227.39	9.21
Хязгаарлагдмал тохиромжтой	19798.52	22.0
Тохиромжтой	67812.3	68.77



5.3. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Зорилго нь Монгол оронд хот, суурин газар байгуулахад тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Шинээр байгуулах хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд шаардагдах хүчин зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн талаар Монгол улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2010 онд боловсруулсан "Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар" (УББ 30-201-09)-т бүрэн тусгагдсан учраас энэхүү батлагдсан баримт бичигт үндэслэн


тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ. Ингэхдээ дээрх аргачилсан зааварт тусгагдсан 4 үндсэн, 43 дэд үзүүлэлтээс 3 үндсэн 19 дэд үзүүлэлтийг хэвээр үлдээж, 1 үндсэн, 16 дэд үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд Схем 14-т тусгагдсан нийт 3 үндсэн, 35 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ. /хүснэгт 34/


1. Байгаль орчны үнэлгээ	2. Инженер дэд бүтцийн үнэлгээ	3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ	
1.1. Газрын гадаргын үнэлгээ;	2.1. Улсын чанартай авто замаар хангагдах байдал;	3.1. Ой бүхий талбай;	3.7. Археологийн үнэт олдвор;
1.2. Гидрологийн үнэлгээ;	2.2. Төмөр замаар хангагдах байдал ;	3.2. Хот суурингийн газар;	3.8. Гол, мөрөн;
1.3.Инженер-геологийн үнэлгээ;	2.3.Агаарын тээврээр хангагдах байдал;	3.3. Зам, шугам сүлжээний газар;	3.9. Булаг, худаг уст цэг;
1.4. Хөрсний үнэлгээ;	2.4. Цахилгааны, дулааны эх үүсвэрээр хангагдах байдал;	3.4. Тариалангийн талбай;	3.10. Манхан элс;
1.5.Байгаль экологийн үнэлгээ	2.5. Хүн ам төвлөрсөн суурин газраас алслагдах байдал;	3.5. Уул уурхайн талбай;	3.11.Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай
		3.6. Түүх соёлын дурсгалт газар;	3.12.тусгай хамгаалттай газар

Схем 14. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний



Хүснэгт 35. Шинээр байгуулах хот, суурин газрын байдлын тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай хэмжээ	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	7696.32	8.56
Тохиромжгүй	718.52	0.50
Хязгаарлагдмал тохиромжтой	52362.17	58.25
Тохиромжтой	2911.39	32.39



5.4. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн бэлчээрийн ургамлын анги, бүлэг төрөл, идэмж, байгалийн бүс бүслүүр, гадаргын нөхцөл, усан хангамж, бэлчээрийн хэв шинж зэрэг үзүүлэлтэд үндэслэн үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээрийн ургамлын 250 анги, бүлэг төрлөөр 7 үндсэн үзүүлэлтэд үндэслэн гүйцэтгэнэ. /хүснэгт 35./

1.Хадлан авах газрыг сонгон шалгуур үзүүлэлт	3.Газар ашиглалтын суурь нөхцөлийн үзүүлэлт
Га-аас авах ургац Шингэх уураг Тэжээлийн нэгж	Хот суурины эдэлбэр газар Ой Тариалангийн газар Уул уурхайн эвдрэлд өртсөн газар Гол нуур Авто зам

Схем 15. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем




Хүснэгт 36. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га


Өвөл-хавар	Талбай, га				
	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад газар ашиглалт	30200.04	30200.04	30200.04	30200.04	30200.04
Тохиромжгүй	277,02	5950.26	356.4	20.25	20.25


Дунд зэрэг тохиромжтой	3294.27	44362.89	53.46	374.22	374.22
Тохиромжтой	40464.36	9323.1	30988.98	7912.08	7912,08
Нэн тохиромжтой	15600.6	-	28237.41	51329.7	51329.7


Хүснэгт 37. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га


Зун-намар	Талбай, га				
	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад газар ашиглалт	30200.04	30200,4	30200,4	30200.04	30200.4
Тохиромжгүй	333.72	394.47	394.47	295.65	295.65
Дунд зэрэг тохиромжтой	1554.39		-	98.82	98.82
Тохиромжтой	38140.47	25249,32	25211.78	10374.48	10374.48
Нэн тохиромжтой	19607.67	33992,46	34020	48867,3	48867.3



























5.5. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн ой- ургамалжлын муж, хошуу, өндрийн бүслүүр ангилалд үндэслэн гадаргын нөхцөл, хөрсний шинж чанарыг илтгэх үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээг байгалийн 3 өөр муж, 9 хошуу, өндрийн бүслүүрээр ялгаатай 22 ойн хэв шинжид үндэслэн нийт 3 үндсэн, 11 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ. /хүснэгт 38/

1.Газрын гадаргын үнэлгээ	2. Хөрсний физик-химийн хүчин зүйлийн үнэлгээ	3. Газар ашиглалтын нөхцөлийн үнэлгээ
1.1. Газрын хэвгий; 1.2.Зүг зовхис 1.3.Гадаргын өнпдөршил	2.1.Хөрсний хэв шинж 2.2.Хөрсний механик бүрэлдэхүүн 2.3.Ялзмагт үеийн зузаан 2.4.Хөрсний ус нэвчүүлэх чадвар 2.5.Хөрсний ялзмагийн агууламж 2.6.Хөрсний урвалын орчин 2.7.Кальцийн карбонат 2.8.Хөрсний цахилгаан дамжуулах чадвар 2.9.Хөрсний чийг	3.1. Ой бүхий талбай; 3.2. Хот суурингийн газар; 3.3. Зам, шугам сүлжээний газар; 3.4. Тариалангийн талбай; 3.5. Уул уурхайн газар; 3.6.Гол горхи, нуур 3.7. Түүх соёлын дурсгалт газар;

Схем 16. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээний




5.6. Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээ”-г боловсруулна.

Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээг хийхэд зураг 1-д тусгагдсан нийт 3 үндсэн, 6 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ. /хүснэгт 39/

1. Авто болон төмөр замын зориулалтаар ашиглаж болох газрын үнэлгээ	2. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглаж болох газрын үнэлгээ
1.1. Газрын гадаргын үнэлгээ	2.1. Газрын гадаргын үнэлгээ
1.2. Инженер-геологийн үнэлгээ	2.2. Инженер-геологийн үнэлгээ
1.3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ	2.3. Уур амьсгалын үнэлгээ
	2.4. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ

Схем 17. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээний





Хүснэгт 38. Авто болон төмөр замын зориулалтаар ашиглаж болох газрын үнэлгээ

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Нэн хүндрэлтэй	358875.37	67.76
Хүндрэлтэй	86727.54	16.37
Хэвийн	84048.01	15.87

Хүснэгт 39. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглаж болох газрын үнэлгээ

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Нэн хүндрэлтэй	1426.33	1.59
Хүндрэлтэй	4757.56	5.29
Хэвийн	83704.31	93.12





5.7. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Экологийн бүс нутгийн үнэлгээний арга зүй: Эко-бүс нутгийн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд: (1) тухайн судалгаанд хамрагдсан газрын биологийн олон янз байдлыг хамтатган төлөөлж чадахуйц зүйл, экосистем, бусад олон янз байдлыг илэрхийлэх сонгосон элементийг тодорхойлж, газрын зурагт буулгах; (2) хамгаалахаар төлөвлөж буй биологийн олон янз байдлын экологи, эволюцийн шаардлагыг удаан хугацааны туршид тэтгэхүйц тоо толгойн элбэгшил, тархацыг тооцсон зорилтыг дэвшүүлэх; (3) хамгаалахаар зорьж буй биологийн олон янз байдлын харьцангуй амьдрах чадвар, экологийн нийлэмж чанар, учрах аюул уршиг, тархац (бүлгэмдэл, популяци, экосистем гэх мэт)-ын төлөв байдлыг үнэлэх; (4) экологийн харьцангуй нийлэмж чанарыг илэрхийлэх, ирээдүйд учирч болох аюул уршгийн хамгийн бага эрсдэлийг даван туулж чадах, хамтдаа төлөөлүүлэн хамгаалах зорилтыг хангаж чадахуйц биологийн олон янз байдлын элементийн тохиолдлыг илрүүлэхэд дээр дурдсан мэдээллийг ашиглана.

Экологийн бүс нутгийн үнэлгээний үе шатууд

Экологийн бүс нутгийн үнэлгээ нь дараах үндсэн 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

I. Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлыг тодорхойлох:

Төлөвлөлт хийх багийг бүрдүүлж, тухайн экологийн бүс нутгийг төлөөлж чадах экосистем, бүлгэмдэл, амьтан ургамлын зүйлүүдийг тодорхойлно.

II. Мэдээлэл цуглуулж, зураглалд оруулах:

Хамгаалахаар сонгосон экосистем, бүлгэмдэл, амьтан ургамлын зүйлүүдийн байршил, одоогийн тоо толгойн төлөв байдлын талаарх мэдээлэл цуглуулж, зураглалд оруулна.

III. Хамгаалах зорилтыг тогтоох:

Хамгаалах биологийн олон янз байдлын экологи, эволюцийн шаардлагыг хангаж чадахуйц тархац нутаг, тоо толгойг харгалзан хамгаалах зорилтыг дэвшүүлнэ.

IV. Амьдрах чадварыг үнэлэх:

Хамгаалах шаардлагатай экосистем, бүлгэмдэл, амьтан ургамлын зүйл тус бүрийн одоогийн төлөв байдлыг тодорхойлсны үндсэн дээр харьцангуй хүний үйл ажиллагаанд бага өртсөн газрыг тогтооно. Энэ үнэлгээг хийхдээ хүний нөлөөллийг


орон зайн хувьд тогтоож, хамгаалах шаардлагатай зүйлийн одоогийн тархац нутагтай давхцуулах аргыг ашиглаж болно.

V. Хамгаалах шаардлагатай газрыг сонгох:

Дээр дурдсан мэдээлэлд үндэслэн бүс нутгийн биологийн олон янз байдлын төлөөллийг хамгаалахад чухал ач холбогдол бүхий чухал газруудыг тогтооно. Экологийн бүс нутгийн үнэлгээний үр дүнд тогтоосон хамгааллын ач холбогдолтой газруудыг “Хамгаалах шаардлагатай газрууд” эсвэл “Биологийн янз байдлын хувьд чухал газрууд” эсвэл “Экологийн хувьд чухал газрууд” гэх мэтчилэн ялгаатай нэрлэж болох хэдий ч агуулгын хувьд зайлшгүй хамгаалбал зохих чухал ач холбогдол бүхий газрууд гэж ойлгох хэрэгтэй юм. Хамгаалах газруудыг тогтооход "Марксан" зэрэг хамгааллын төлөвлөлт боловсруулахад хэрэглэдэг компьютерийн программ ашиглана.

Хүснэгт 40. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ



Үнэлгээ	Талбай
Бусад газар ашиглалт	34927.24
Хадгалан хамгаалах тохиромжтой газар	54879.49





Зургаадугаар бүлэг. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Олон нийтийн санал ба оролцоо

Тус сумын ИТХ-ын ажлын тайлангийн хурал 2017 оны 10 сарын 4-нд сургуулийн урлаг зааланд болж нийт 62 иргэн оролцсон. Хурлын үеэр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний талаарх ойлголт, мэдээллийг өгч, сумын нутаг дэвсгэрт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар ярилцан санал бодлоо солилцсон. Иргэдээс төлөвлөгөөнд оруулах саналыг нь саналын хуудас тараан авсан болно.





Зураг Иргэд, малчдаас авсан саналын хуудас

Хүснэгт 41. Шивээговь сумын иргэдээс авсан саналын товчоо

№	Суманд хэрэгжүүлэх шаардлагатай хэмжээний санал	Арга хэмжээний үр өгөөжийг хүртэгчид	Ашиг хүртэгчдийн тоо	Үзүүлэх нөлөөлөл	Хэрэгжих хугацааны төсөөлөл /он/
1	Бэлчээрт худаг гаргах	Малчин, мал бүхий өрх	149	Бэлчээрийн худгийн хүрэлцээ нэмэгдэнэ.	2018 онд
2	Эрчимжсэн мал аж ахуйн газрыг цахилгааны эх үүсвэртэй болгох	Сумын нийт иргэд	3378	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломж бүрдэнэ.	2019 онд
3	Бэлчээрийн хортон мэрэгч устгах	Малчин, мал бүхий өрх	149	Бэлчээрийн даац, хүрэлцээ нэмэгдэнэ.	2018-2022
4	Шивээговь сумын төвийг улсын чанартай автозамтай холбох	Сумын нийт иргэд	3378	Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл бүрдэж, бэлчээрийн талхлалт багасна.	2018 онд
5	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад бут, сөөг тарих усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх зардал	Сумын нийт иргэд	3378	Сумын өнгө үзэмж сайжирна.	2018-2019
6	Өвс тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх	Малчин мал бүхий өрх	149	Өвс, тэжээлийн нөөц бий болно.	2019

7	Малын үүлдэр угсааг сайжруулах	Сумын нийт иргэд	3378	Мал сүргийн чанар сайжирна.	2019-2020
8	Бэлчээрийг олон наст ургамлаар сэргээх зардал	Малчин, мал бүхий өрх	149	Бэлчээрийн даац нэмэгдэнэ.	2018-2022
9	Сумын туурь хогийг цэвэрлэх	Сумын нийт иргэд	3378	Сумын иргэд цэвэр орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.	2018-2020
10	Эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгрүү халуун усны шугам татах	Сумын нийт иргэд	3378	Сурагчид болон ажилтануудын ажиллах таатай орчин бүрдэнэ.	2019-2021
11	22-р зөрлөгт сагс, гар бөмбөгийн иж бүрэн талбайтай болох	22-р зөрлөгийн иргэд	70	Залуусын чөлөөт цагаа өнгөрөөх орчин бүрдэнэ.	2019-2020
12	Сумын төвд засмал замтай болох	Сумын нийт иргэд	3378	Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.	2019-2021
13	Гэр хорооллыг төвийн шугамтай холбох	Гэр хорооллын иргэд		Иргэдийн тав тухтай амьдрах орчин бүрдэнэ.	2019-2022
14	Ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэгтэй болох	Сумын нийт иргэд	3378	Иргэд нэг цэгээс үйлчилгээ авах боломж бүрдэнэ.	2020-2021
15	Оршуулгын газрыг хашаатай болгох	Сумын нийт иргэд	3378	Оршуулгын газрын хил хязгаарыг тогтооно.	2019-2022
16	Үйлчилгээний төвтэй болох \мах, сүү ногоо, түүхий эд\	Сумын нийт иргэд	3378	Үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	2019-2020
17	Спорт цогцолбортой болох	Сумын нийт иргэд	3378	Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нөхцөл бүрдэнэ.	2021-2022
18	Хүүхдийн тоглоомын паркттай болох	Сумын нийт хүүхэд	1120	Хүүхэд тоглох таатай орчин бүрдэнэ.	2020
19	Элсний нүүдлээс сэргийлж мод тариалах, тарьсан модоо арчилах	Сумын нийт иргэд	3378	Элсний нүүдэл багасна.	2019-2021
20	Гэр хорооллын гудамжуудыг хаягжуулах	Сумын нийт иргэд	3378	Сумын өнгө үзэмж нэмэгдэнэ.	2018-2019
21	Байрнуудын дундах талбайг зүлэгжүүлэх	Орон сууцны байрнууды	210 өрх	Байрнуудын гадна өнгө үзэмж сайжирна.	2019-2020

		н оршин суугчид			
22	Хаягдал бохир зайлуулах шугамыг 1.7 км-т зайлуулж холдуулах	Сумын нийт иргэд	3378	Иргэдийн амьдрах таатай орчин нөхцөл бүрдэнэ.	2021-2022

6.1. ХАА-Н АНГИЛЛЫН ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БҮСҮҮД, ТҮҮНИЙ НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Хөдөө аж ахуйн ангиллын газарт бэлчээрийн газар, тариалангийн газар, хөдөө аж ахуйн барилга, байгууламжын газрууд орно. Шивээговь сум нь бусад сумаас ялгарах гол онцлог нь харьцангуй газар нутаг багатай, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэж хөгжиж байгаа зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд талхлагдсан бэлчээрийг улирал, сараар сэлгэх, өнжөөж амраах, малчдын бүлэг байгуулж бэлчээрийг хэсгээр ашиглах, өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэхдээ баримтлах хэмжээ ба зарчим, хагас эрчимжсэн ба эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх зэрэг асуудлыг тусгалаа. Хөдөө аж ахуйн газрын дэд ангиллуудаар төлөвлөлтийг дор дурьдсанаар боловсруулав.

6.1.1. Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө

Бэлчээрт хамгийн их нөлөөлөл үзүүлж буй хүчин зүйл нь малын тоо толгойн өсөлт байна. Бэлчээрийн ургамлын бүтцийн өөрчлөлтөнд хүн, мал амьтны үйл ажиллагаа ихээхэн нөлөөтэй. Иймээс бэлчээр ашиглалтыг зохицуулахдаа түүний даацыг нарийн тохируулах шаардлагатай юм.

Хүснэгт 42. Бэлчээрийн даац, түүний хэтийн ашиглалт

№	Сумын нэр	Бэлчээрийн талбай	Га-ийн ургац /цн/	Бэлчээрийн нөөц /цн/га/	Бэлчээрийн багтаамж	2022 онд байх малын тоо/хонин толгой	Даац ашиглалт т-+ %
3	Шивээговь	82472.0	2.8	230921,6	41236	72627	-1.7

2022 онд Шивээговь сум хонин толгойд шилжүүлснээр 72 мянга орчим малтай болох урьдчилсан тооцоог гаргасан бөгөөд тэр үед бэлчээрийг 1.7 дахин хувиар

хэтрүүлэн ашиглана гэсэн баримжаа байна. Иймээс малын тоо толгойг өсгөхөөсөө илүү чанарт анхааран малын үүлдэр угсааг сайжруулан эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

6.1.1.1.Бэлчээрийг улирал, сараар сэлгэн ашиглах төлөвлөгөө

Говьсүмбэр аймгийн хэмжээгээр нийт 90814 га бэлчээрийн газар бага зэргийн талхагдалд орсон байна. Үүнээс Шивээговь суманд 16001 га бэлчээр байна.

Эдгээр бэлчээрийн газруудад бэлчээрийн ургамлын сэргэн ургалтыг дэмжих үүднээс бутлалын болон үр боловсрох үеэр бэлчээрийг аль болох хөнгөн ашиглах, ачааллыг бууруулах зорилгоор энгийн хуваарьтай ашиглах.

Энгийн хуваарьтай ашиглалтыг нэвтрүүлж, бэлчээрээ 5-7 хэсэгт хувааж шон, чулуун овоо босгох, байгалийн таних тэмдгийг ашиглан ээлжлэн ашиглах, байнгын хариулгаар малаа бэлчээрлүүлэх. Бутлалтын болон үр боловсрох үеэр бэлчээрийг аль болох чөлөөлөх зорилгоор сарын хугацаанд 2 талбайт сэлгээг нэвтрүүлэх шаардлагатай. Бэлчээр хүрэлцээтэй нөхцөлд 1 зуны турш ашиглалтаас чөлөөлөх нь үр дүнтэй.

Хүснэгт 43. Шивээговь сумын улирал, сараар сэлгэн ашиглах бэлчээр

№	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөж буй арга хэмжээ	Хэрэгжүүлэх ажиллагаа үйл	Хугацаа /он/
1	Хөтөлийн худгаас баруун хойш Хөтөлийн ухаа-Найман толгой хүртэл	16001	Улирлаар сэлгэх	Бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах тухай нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах. Үүний дагуу малчидтай бэлчээрийг улирал, сараар сэлгэх 3 талт гэрээ байгуулах. Шийдвэр ба гэрээний биелэлтэд багийн Засаг дарга нар хяналт тавих. Гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулал болон хариуцлага тооцох.	2019
2	Нэртийн Ухаагаас зүүн урагшаа Эрдэнэ толгой-Бөхтийн худаг хүртэл				2018
3	22-р зөрлөгөөс Нэртийн хонхор хүртэл				2020
	БҮГД	16001			

6.1.1.2.Бэлчээрийг жилээр сэлгэн ашиглах төлөвлөгөө

Говьсүмбэр аймгийн хэмжээгээр нийт 96589 га бэлчээр дунд зэргийн талхагдалд орсон байна. Үүнээс Шивээговь суманд 5000 га бэлчээр байна.

Дунд зэргийн талхагдалд орсон бэлчээрийн газрыг 3 жил дараалан ургамлан нөмрөг сэргэтэл ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Ачааллыг боломжит даацаас 15 хувиар багаар тооцон 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах. Ахин 3 жилээр ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Малын тоог боломжит даацаас 15 хувиар багаар тооцон ахин 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах нь зүйтэй. Мөн бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготонотой тэмцэж хор цацах, биологийн аргаар тэмцэх, утах, ус цутгах гэх зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй.

Хүснэгт 44. Шивээговь сумын жилээр сэлгэн ашиглах бэлчээр

№	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөж буй арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/
1	Хөвийн хоолойгоос зүүн тийш Бөхт уул	5000	Жилээр сэлгэн ашиглалтаас чөлөөлөх	Бэлчээрийг жилээр сэлгэн ашиглах тухай нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах. Үүний дагуу малчидтай бэлчээрийг жилээр сэлгэх 3 талт гэрээ байгуулах. Шийдвэр ба гэрээний биелэлтэд хяналт тавих. Гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулал болон хариуцлага тооцох. Отор нүүдэл хийх газрыг заан өгөх.	2018
2	Гозгор толгойгоос зүүн урагш Урсахын өндөр ухаа хүртэл				2021
3	Шагшуургын хонхороос баруун хойш Эрээн сүмийн туурь хүртэл				2019
4	Бөхт уулын орчим				2022
	БҮГД	5000			

Дунд зэрэг талхагдалд орсон бэлчээрийн бүлгэмдэлд зонхилогч, дэд зонхилогчийн үүрэг солигдсон, ургамал нөмрөгт агь, шарилж болон талхагдлыг илэрхийлэгч бусад ургамал орж ирсэн, идэмж сайтай үет, буурцагт ургамлын оролцоо багассан, бут хоорондын сул зайд хөрс хучлагагүй болж иүцгэрсэн, олон төрлийн мэрэгч олширсон, ургамлын бүрхэц багассан байна.

6.1.1.3.Бэлчээрийг чөлөөлөх өнжөөж, амраан ашиглах төлөвлөгөө


Говьсүмбэр аймгийн хэмжээгээр нийт 98453 га бэлчээр хүчтэй талхагдалд орсон байна. Үүнээс Шивээговь суманд 20241 га бэлчээр байна.

Хүчтэй талхагдалд орсон бэлчээрийн газарт олон наст ургамлын бүрхэцийг нэмэгдүүлэх замаар өнгөн хөрсний тогтвортой байдлыг хангах нь чухал. Идэмж сайтай үндсэн зүйл ургамлууд бараг устаж үгүй болсон тул эргэн сэргэхдээ удаан 10-аад жил шаардагдана. 3 жил дараалан ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Ачааллыг боломжит даацаас 15 хувиар багаар тооцон 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах. Ахин 3 жилээр ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Малын тоог боломжит даацаас 15 хувиар багаар тооцон ахин 2 жил дараалан ургамал нөмрөг сэргэтэл ургамал ургалтын хугацаанд ашиглах нь зүйтэй.

Хүснэгт 45. Ашиглалтаас чөлөөлөх, өнжөөж амраах бэлчээр

№	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөж буй арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/
1	Өөхийн цагаан толгойгоос зүүн урагш Хүхээгийн сайраас зүүн урагш-Цагаан бух толгой орчим	7623	Ашиглалтаас чөлөөлөх, 3 жил дараалан өнжөөж амраах	Бэлчээрийг чөлөөлөх, 3 жил өнжөөж амраах тухай нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах. Үүний дагуу малчидтай бэлчээрийг ашиглалтаас чөлөөлөх 3 талт гэрээ байгуулах. Шийдвэр ба гэрээний биелэлтэд хяналт тавих. Гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулал болон хариуцлага тооцох. Бэлчээр чөлөөлөх үед отор нүүдэл хийх газрыг заан өгөх, өөр аймаг, сумын нутагт оторлох бол сумдын удирдлагуудын түвшинд тохиролцон хамтран шийдвэр гаргах.	2018
2	Сэвхүүлийн хонхор орчим	815			2019
3	Нэргийн хонхороос зүүн урагш Бэхтийн ухаа орчим	6181			2020
4	Хүрэн дух толгойгоос зүүн урагш Ихэр цагаан толгой орчим	4569			2021
5	Шагшуургын хонхороос баруун хойш Мөнхөг нуур орчим	1308			2022
	БҮГД	20241			

Хүчтэй талхагдсан бэлчээрийн бүтэц бүрэлдэхүүн үндсээрээ өөрчлөгдөж, агь, шарилж болон талхлагдлыг илэрхийлэгч бусад ургамал зонхилсон, нэгж талбайд байх ургамлын тоо эрс цөөрч, шингэрсэн, мал иддэг ургамал бараг үгүй болсон бүрхэцийг мал иддэггүй ургамал бүрдүүлэх болсон, хөрсний өнгөний үржил шимтэй хэсэг салхинд хийсч хайргажин хөрс нягтарсан бутны ёроолд элс шуурч хурсан, оготоно зурамны нүх эзгүйрч, үлий хоосорсон байна.



6.1.1.4. Бэлчээрийн улирлын хуваарийн төлөвлөлт

Бэлчээрийн газрыг зун-намрын, өвөл-хаврын гэсэн ерөнхий хуваарьтай ашигладаг уламжлал бараг алдагдаж ихэнх малчид отор нүүдэл хийхгүй жилийн

дөрвөн улиралд суурин байж сум, багийн төв орчим болон булаг шанд, голын хөндий, нуур тойром орчмын бэлчээрийг давтан ашигласнаар бэлчээр талхагдаж доройтон муудсаар ургамал нөмрөг нь сийрэгжин хазаар өвс, шарилж, лууль, агь зэрэг ургамал эрс ихсэн унаган төрх нь алдагдсаар байна.

Бэлчээрийг зөв зохион байгуулалттай, дэс дараатай ашиглуулахын тулд бэлчээр ашиглах улирлыг 4-өөр тогтоох нь чухал юм. Үүнд:

1. Хавар эрт ашиглах бэлчээр /3, 4, 5 дугаар сард/
2. Зунд ашиглах бэлчээр /6 дугаар сарын 2-р хагасаас 7, 8-р сарууд/
3. Намар ашиглах бэлчээр /9, 10, 11-р сарууд/
4. Өвлийн бэлчээр /12, 1, 2 дугаар сар/-уудад ашиглах.

Бэлчээрийг ийм хуваарьтайгаар ашиглах нь өвөл-хаврын хэцүү улирлыг өнтэй өнгөрүүлэх, малыг нэмэгдэл тэжээлээр тэжээх бэлтгэлийг урьдаас төлөвлөн хангах, бэлчээр, хадлангийн талбайг хамгаалах боломжийг олгоно.

6.1.1.5.Бэлчээрийн усан хангамж

Усны нөөцийг зохистой ашиглаж хамгаалахад эдийн засгийн хөшүүрэг, механизмыг хэрэглэн ус ашигласны төлбөрийг ногдуулж, хуримтлуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлж эхлээд нилээдгүй хугацаа өнгөрсөн боловч энэ хөрөнгө усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалахад чиглэгдсэн оновчтой арга хэмжээнд бус, орон нутгийн төсөвт зарцуулагдаж байгаагаас нутаг бэлчээрийг усжуулах, уст цэгүүдийг хамгаалах, усны нөөцийг арвижуулах ажил зогсонги байдалтай байна. Энэ байдалд дүгнэлт хийж ус, рашаан ашигласны төлбөрийг оновчтой тогтоох, төлбөрийг усны аж ахуйн менежментэд зарцуулах, худаг ус гаргах ажлыг төрийн бодлогоор дэмжих замаар нутаг бэлчээрийн ашиглалтыг сайжруулах нь чухал.

Энэ тайлбар бичгийн “Усны сан бүхий газрын хамгаалалт, ашиглалтын төлөвлөгөө” хэсэгт гол, горхи, булаг, шанд, нуур, худаг усны хамгаалалтын бүсийг татаж, зурагт харуулсан болно.

Бэлчээр дэх худгийн мал усалгааны радиусыг хээрийн бүс нутагт бог мал ба үхэр услах 2.5 км-ээр тогтоолоо. Сумын хэмжээгээр усжуулагдсан бэлчээр 50296 га, усжуулагдаагүй 39140 га бэлчээр байна.

Хүснэгт 46. Усжуулагдсан бэлчээрийн талбай

Гадаргын усны төрөл	Тоо хэмжээ	Нэг худгийн мал усалгааны радиус	Нэг худгийн усжуулсан талбайн хэмжээ /га/	Усжуулагдсан нийт бэлчээрийн хэмжээ /га/	Усжуулагд аагүй талбайн хэмжээ /га/
Бэлчээрийн усан хангамж, худаг	90	2.5 км	1963 га	50926	39140

Шивээговь суманд бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар нийт 90 худаг ашиглагдаж байгаагийн 70 гаруй худаг нь ажиллагаатай, 5 худаг ямар нэгэн байдлаар эвдэрсэн байна. Эвдэрсэн худгийг сэргээн засварлаж ашиглалтгүй бэлчээрийг эргэлтэд оруулах арга хэмжээг дор дурьдсанаар төлөвлөв.

Хүснэгт 47. Эвдэрсэн худгийг сэргээн засварлах төлөвлөгөө

Худгийн байршил	Худгийн төрөл	Ашиглалтад орсон он	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Хугацаа /он/
Шивээговь					
Хөтөл	Энгийн уурхай	0	засварлах		2018-2019
Бөгсийн арын голын бууц	БХУХ	0	засварлах		2018-2019
Улаан зээг	БХУХ	0	засварлах		2018-2019
Шивээгийн зоо	Ө/Х	2010	засварлах		2018-2019
Бэлхийн улаан өндөр	БХУХ	1969	засварлах		2018-2019

Хүснэгт 48. Уст цэгүүдийг сэргээн засварлах болон шинээр уст цэгүүд гаргах зардлын томсгосон үзүүлэлт (сая төгрөг)

№	Сумын нэр	Засварлах худаг						Шинээр гаргах			Сумын хэмжээнд шаардагдах нийт зардал (сая төг)	Усжуулагдах бэлчээр (мян га)
		Өрөмдмөл			Энгийн уурхай			Гүн өрмийн				
		Тоо (ш)	Нэгж зардал	Нийт зардал	Тоо (ш)	Нэгж зардал	Нийт зардал	Тоо (ш)	Нэгж зардал	Нийт зардал		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Шивээговь	1	4.5	4.5	4	2.5	10.0		9.0			
	Дуну			4.5			10.0					

6.1.1.6. Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх талаар


“Газрын тухай” хуулийн 52 дугаар зүйлийн 52.7 дах заалтад “Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно” гэж заасан боловч газрын хэмжээг тодорхой заагаагүй байдаг нь энэ зориулалтаар бэлчээрийн газрыг ашиглуулах, эзэмшүүлэхэд хүндрэл тулгардаг бөгөөд орон нутгууд янз бүрийн хэмжээгээр газрыг эзэмшүүлж, ашиглуулдаг байна.

Малчин, хот айл өвөл, хаврын улиралд ойр орчмын газартаа малаа бэлчээх зорилгоор уулын энгэр, нөмөр газрыг сонгон хүн, малын ая тухтай байх нөхцөлийг бүрдүүлж, өөрийн гэр, сууц, малын хашаа хороо, саравч, бууц, өвс, тэжээлийн хашаа, мал нарладаг талбай, морины уяа, нөөцөлсөн түлээ, түлшний байр, үнс, хог хаях газар, ариун цэврийн газар зэргийг барьж байгуулан ашиглаж байгаа газрыг өвөлжөө, хаваржааны доорх газар гэдэг.

Хүснэгт 49. Өвөлжөө, хаваржааны доорх газрын жишиг хэмжээ

№	Өвөлжөө, хаваржааны доорх газрын бүтэц	Хангайн бүс	Говийн бүс	Тал хээрийн бүс
1	Малчны гэр, сууцны газар	56-100 м ²	56-100 м ²	56-100 м ²
2	Түлээ нүүрсний байр	2-4 м ²	2-4 м ²	2-4 м ²
3	Үнс хог хаях газар	3-6 м ²	3-6 м ²	3-6 м ²
4	Ариун цэврийн байр	1-2.5 м ²	1-2.5 м ²	1-2.5 м ²
5	Малын хашаа хороо, саравч, пүнз	100-600 м ²	100-700 м ²	100-800 м ²
6	Бууц асгах газар	10-20 м ²	10-20 м ²	10-20 м ²
7	Өвс тэжээлийн хашаа	15-25 м ²	15-25 м ²	15-25 м ²
8	Мал нарладаг талбай	200-700 м ²	300-800 м ²	400-900 м ²
9	Морины уяа	20-50 м ²	20-50 м ²	20-50 м ²
Бүгд хэмжээ /м ² /		400-1500 м ²	500-1700 м ²	600-1900 м ²
Нийт тойргийн хэмжээ /га/		0.07-0.2	0.09-0.3	0.1-0.4

Өвөлжөө, хаваржааны доорх газрын хэмжээг
сансрын зураг ашиглан тодорхойлсон зураг
Жишээ



Тэгэхээр Говьсүмбэр аймаг нь тал хээрийн бүсэд багтах бөгөөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг 0.1-0.4 га-аар эзэмшүүлэх нь тохиромжтой хэмжээ юм.

Өвөлжөө, хаваржааны доорх газарт хамгийн их зай, талбай эзлэх газар нь малын хашаа хороо, саравч, пүнз болон мал нарладаг талбай байдаг. Тиймээс малын хашаа, саравчны талбайн хэмжээ, багтаамжийг бод болон бог малын хэвтрийн эзлэх хэмжээгээр тооцож гаргана. Мөн мал нарладаг талбайн хэмжээг бод, бог малын хэвтрийн хэмжээгээр тооцно.

Хүснэгт 50. Бод малын хашаа, саравчны талбайн хэмжээ, багтаамжийг тооцох

Үзүүлэлт	Үхрийн нас, хүйс	Хэмжих нэгж	Саравчны хэвтрийг тооцох талбай	
Монгол үхэр	1	6 сараас дээш настай тугал	M ²	1.0-1.2
	2	Бяруу	M ²	1.0-2.0
	3	Гунж, шүдлэн	M ²	2.2-2.4
	4	Хээлтэй үнээ	M ²	2.8-3.0
	5	Тугалтай үнээ	M ²	4.2
	6	Нас гүйцсэн шар, бух	M ²	4.5-5.0
Сарлаг үхэр	7	Тугал	M ²	0.8-1.0
	8	Бяруу	M ²	1.4-1.8
	9	Гунж, шүдлэн	M ²	2.0-2.2
	10	Хээлтэй үнээ	M ²	2.6-2.8
	11	Тугалтай үнээ	M ²	3.8-4.0
	12	Нас гүйцсэн шар, бух	M ²	4.5-5.0

Үхрийн өвөлжөөний хашааны багтаажийг тооцохдоо шөнө саравчинд хэвтүүлэх, орой, өглөө 1-2 цаг нарлах хашаанд байлгаж шээлгэх, цан хүүргийг унагах, суурийн нийт үхрийн 50 орчим хувьд нэмэгдэл тэжээл өгч байх технологийг үндэс болгоно.

Хонь, ямааны нас хүйс, үүлдэр угсаанаас хамааран эзлэх зай нь битүү дулаан пүнз болон саравчтай хашаанд ялгаатай байна.

Хүснэгт 51. Бог малын хашаа байрны талбайн хэмжээ, багтаамжийг тооцох /м²/

№	Малын нас, хүйс, үүлдрийн ялгаа	Битүү дулаан байр	Саравчтай хашаа
1	Нарийн нарийвтар ноост хонь, ноолуурын ямаа	1.0	0.6
2	Нутгийн үүлдрийн хонь, ямаа	0.7	0.5
3	Эр, сувай, өсвөрийн хонь, ямаа	-	0.4

Бог малын хашааны багтаамж нь хэвтрийн, нарлагааны, тэжээллэгийн, бусад гэсэн 4 хэсгээс бүрдэнэ. Бог малын хашаа, байрны талбайн хэмжээг дараах журмаар тооцно.

Хашааны багтаамж:

$$ХБТ = X + H + T + B \text{ м}^2$$

$$X\text{-хэвтрийн талбай, } x = N \times S \text{ м}^2$$

N-нэг суурьт байх малын дундаж тоо

S-нэг малд ногдох талбай

Нэг суурьт нийт эм хонь, ямаа 650 толгой бол $X = N \times S$

$650 \times 0.6 = 390 \text{ м}^2$ хэвтрийн талбайтай байна.

H-нарлагааны талбай, $H = K_1 \times X \text{ м}^2$ $K_1 = 2.0$

Нэг толгой нэг настай малын хашааны нарлагааны талбай $= 0.4 \times 2 = 0.8 \text{ м}^2$

Суурийн нэг наст малын тоо 800 толгой бол $H = 800 \times 0.8 = 640 \text{ м}^2$

T-тэжээллэгийн талбай, $T = K_2 \times H \text{ м}^2$ $K_2 = 1.5$

Нэг толгой эм хонь, ямааны тэжээллэгийн талбай $1.5 \times 640 = 960 \text{ м}^2$ болно.

Нийт суурийн 650 толгой малд $T = 1.8 \times 650 = 1170 \text{ м}^2$ болно.

Нийт 650 толгой малтай нэг суурийн хашаа, байрны талбайн хэмжээ нь 2200 м^2 гарч байна.

Тус аймагт өөр аймаг, сумын буюу Дундговь аймгийн Цагаандэлгэр, Төв аймгийн Баян, Баянжаргалан, Дорноговь аймгийн Даланжаргалан зэрэг сумдаас малчид отор нүүдэл хийж орж ирэн бэлчээр усыг ашиглаж байгаад нутгийн малчид

ихээхэн дургүй бөгөөд бэлчээрийн маргаан ч гардаг байна. Мөн малчид өөрсдийн өвөлжөө, бууцаа тэдэнтэй наймаалцаж, гадны малчдыг өөрийн нутагт байрлуулж бэлчээрийн даац ашиглалтыг нэмэгдүүлж байна. **Сүмбэр сумын Тэвшийн 4-р багийн** иргэдийн нийтийн хурал 2017 оны 10 сарын 4-нд хуралдаж, өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэхдээ дараах зарчмыг баримтлахаа хуралд ирсэн малчид тохиролцсон юм. Үүнд:

- Энэ онд өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэхгүй байх
- Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшсэн бол дахин газар олгохгүй байх
- Тус багт шилжиж ирээд дор хаяж 3 жил амьдарч, иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнөө хийлгэж бүртгүүлсэн малчдад л газар эзэмшүүлэх
- Малаа өөрийн гараар маллаж байгаа малчин өрхөд газар эзэмшүүлэх
- Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд газар эзэмшүүлэх зэрэг зарчмыг бусад багууд баримтлан өвөлжөө, бууцын доорх газрыг эзэмшүүлэх нь зүйтэй юм.

6.1.1.7. Малчдын бүлэг, бэлчээр ашиглалтын хэсэг байгуулах талаар

Зах зээлийн нийгэмд шилжсэн өнөөгийн нөхцөлд малчид малын тоо толгойг дураараа өсгөж ашиг олох зорилгоор бэлчээр нутгийг хайр гамгүй ашиглан талхлан доройтуулж, үржил шимгүй болгон нөөцийг шавхан ашиглах явдал гарсаар байна. Мөн нөгөө талаас байгаль, цаг уурын нөлөөлөл, хуурайшилтаас хамаарч бэлчээрийн төрх байдал өөрчлөгдөх, элсний нүүлт ихсэх, булаг, шанд ширгэх зэрэг шалтгаанаар бэлчээрийн газар өдөр ирэх тутам багассаар байгаа нь газар зохион байгуулалтын тулгамдсан асуудлын нэг болоод байна.


Дэлхийн банкны санхүүжилтээр “Бэлчээрийн эрсдлийн менежментийг сайжруулах төсөл” Говьсүмбэр аймагт 2007 онд хэрэгжиж сум, багт малчдын бүлэг байгуулан, газар нутгийг малчдын бүлгийн хил, заагт хуваах ажлыг хийсэн. Гэвч энэ нь амьдрал дээр хэрэгжээгүй, цаасан дээр зураг болж үлдсэн байна.

“Газрын тухай” хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дах заалтад “... Өвөлжөө, хаваржааны **тодорхой нутаг бэлчээрийг** ... малчдад болзол, гэрээний дагуу хэсэг, бүлгээр ашиглуулж болно” гэж заасан.

Бид энэхүү төлөвлөлтийн ажлын хүрээнд Шивээговь сумын хэмжээгээр малчдын өвөлжөө, хаваржаа орчмын бэлчээр нутгийн хэмжээ, хил заагийн хувилбар боловсруулж зураглах ажлыг гүйцэтгэлээ. Уг хувилбарыг боловсруулахдаа малыг

хашаа байрнаас нь бэлчээрт идээшлүүлэх тохиромжтой зайг буюу богино хөлт мал өвөл-хаврын улиралд бэлчих 3 км хүртэлх зайг баримталж тогтоосон болно.

Энэхүү тогтоосон өвөлжөө, хаваржаа орчмын бэлчээрийн хэмжээ, заагийг баримтлан цаашид малчдад өвөлжөө, хаваржааны газар шинээр эзэмшүүлэх болон өвөлжөө бууц хоорондын зайг тогтоож болно.



6.1.1.8. Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийн төлөвлөлт

Мал аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэгчдийн хувьд байгаль цаг уураас хараат учир эрсдэл орох магадлалтайг харгалзан цаашид тодорхой хэмжээнд эрчимжүүлсэн хэлбэрээр аж ахуй эрхлэн явуулснаар байгалийн гамшигийн нөлөөллөөс тодорхой хэмжээнд сэргийлэх боломжтой юм.

Төлөвлөлтийн эцэст буюу 2022 он гэхэд сумын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээнд зориулан жилд 67.9 литр үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, мөн тооны уламжлалт аргаар боловсруулсан сүү, 90.5 литр сүүн бүтээгдэхүүн худалдаж байх шаардлага гарна.

Хүснэгт 53. Шивээговь сумын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүний нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он		
				Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	
2	Сүү	54.8	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү	1	1124	61595.2	1153	63184.4	1182	64773.6	1211	66362.8	1240	67952
		54.8	Уламжлалт аргаар боловсруулсан сүү	1	1124	61595.2	1153	63184.4	1182	64773.6	1211	66362.8	1240	67952
3	Сүүн бүтээгдэхүүн	73			1124	82052	1153	84169	1182	86286	1211	88403	1240	90520

Мөн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 2030 он гэхэд аймгийн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээнд зориулан жилд 1067.7 литр үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, мөн тооны уламжлалт аргаар боловсруулсан сүү, 1422.3 литр сүүн бүтээгдэхүүн худалдаж байх шаардлагатай гэж тусгагдсан.

Шивээговь сум нь газар нутаг багатай, Чойр хотод ойр, зам харилцаа, гэрэл цахилгааны хангамж сайтай зэрэг давуу тал болон нөхцөл байдалдаа тохируулан малынхаа үүлдэр угсааг сайжруулан чанар сайтай, цөөн тооны малыг хагас эрчимжүүлэн суурин хэлбэрийн аж ахуй эрхлэх шаардлагатай.

Мөн Чойр хот ирээдүйд томоохон хот суурин болон хөгжиж хотжилт эрчимтэй өсөх бүрэн боломжтой тул аймгийн болоод сумын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангахын тулд Шивээговь сумын нутагт эрчимжсэн суурин аж ахуй хөгжүүлэх боломжтой юм.

Хүснэгт 54. Говьсүмбэр аймгийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ,
хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /л/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг шилжүүлэн коэффициент тооцох		2018-2020 он		2021-2025 он		2026-2030 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/
2	Сүү	54.8	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү	1	17053	934504.4	18268	1001086.4	19484	1067723.2
		54.8	Уламжлалт аргаар боловсруулсан сүү	1	17053	934504.4	18268	1001086.4	19484	1067723.2
3	Сүүн бүтээгдэхүүн	73			17053	1244869	18268	1333564	19484	1422332

Чойр хотын хүн амыг дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр түргэн шуурхай хангах зорилгоор эрчимжсэн суурин мал аж ахуйн бүс нутгийг хэрэглэгчдэд хамгийн ойр зам, харилцаа сайтай газар төвлөрүүлэх. Сүүг аль болох хямд үйлдвэрлэхэд дөхөм үзүүлэх нөөц боломж, эрчим хүч, түлш зэрэг холбогдох асуудлыг харгалзан Шивээговь суманд сүүний чиглэлийн эрчимтэй фермерийн аж ахуйн чиглэл бий болно гэж үзлээ.

Говьсүмбэр аймгийн сүүний эрэлтийг дотоодын сүүгээр хангахын тулд Шивээговь суманд 1 ширхэг 30 үнээний фермерийн аж ахуй, 1 ширхэг 50 үнээний фермерийн аж ахуй байршуулах шаардлагатай байна.

Хүснэгт 55. Шивээговь суман дах сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн тоо

Он	Фермерийн аж ахуйн тоо	
	30 үнээтэй	50 үнээтэй
2018-2020	1	-
2021-2022	-	1

Сүү бол өдөр тутмын хүнсний хэрэгцээний 20-25 хувийг эзэлж байх шаардлагатай бөгөөд сүүнээс гадна бусад төрлийн цагаан идээ, тараг, аарц, ааруул, ээзгий, гүүний айраг, лаазтай өтгөрүүлсэн ба хуурай сүү нилээд хэмжээгээр хэрэгтэй.

Энэхүү дэд бүсэд фермерийн аж ахуйн суурингаас гадна таримал хадлан бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах, дарш бэлтгэх талбайг оролцуулан иргэн, аж

ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй гэрээний дагуу газрыг хуваарилж тухайн жилийн төлөвлөгөөнд хэсэгчилэн зааж оруулан ашиглуулна.

Сүүний үхэрт тохирох хүрэлцэхүйц бэлчээр, хадлангийн талбай, тэжээлийн ургамал тариалах, таримал хадлан бэлчээр бий болгох боломж өөрөөр хэлбэл саалийн аж ахуйд гаднаас худалдаж авахгүй зөвхөн өөрийн үйлдвэрлэлийн тэжээлээр хангаж байх зарчмыг баримтлах нь зүйтэй хэмээн үзэж өндөр ашиг шимтэй сүүний чиглэлийн үхрийн аж ахуй нь өөрийн үйлдвэрлэлд шаардагдах шүүст тэжээл ба хадлангийн хэрэгцээг өөрсдөө хангахаар тооцов.

Хүснэгт 56. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйд жилд шаардагдах тэжээл, тариалангийн ба хадлангийн талбайн хэрэгцээ

Он	Сүүний чиглэлийн үнээний фермерийн тоо	Талбайн хэмжээ га	Жилд шаардагдах тэжээл, мян.т		
			Үүнээс /га/		Нэмэлт тэжээлийн талбай 15%
			Таримал, хашсан бэлчээр 80%	Суурингийн талбай 5%	
2018-2020	1	900	720	45	135
2021-2022	1	1000	800	50	150

Сүүний үхэр сүргийн үүлдрийг сайжруулан өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн үхэр сүргийг голчлон хөгжүүлж, үхэр сүргийн дотор өндөр ашиг шимтэй үнээний эзлэх хувийн жинг тогтоож хэрэгжүүлэх. Мөн үнээний 60-аас доошгүй хувийг жил бүрийн 9-12-р сард төллөхөөр хээлтүүлэх ажлыг хотын сүүний хэрэгцээг харгалзан зохион байгуулах хэрэгтэй юм.

6.2. ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Хот суурин газрын ашиглалт хязгаарлагдмал орон зайд олон төрлийн зориулалтаар ашиглагддаг, нягтрал ихтэй, эзэмшил ашиглалтын нарийн горим хувиарлалттай, экологийн хямралд нэн өртөмтгий байдаг онцлогтой. Шивээговь сум нь дэд бүтцийн хөгжлөө дагасан суурьшмал амьдралтай боловч үндэсний уламжлалт нүүдлийн мал аж ахуйн зэрэгцээ үйлдвэр, уурхай болон Оросын цэргийн ангийн бүтээн байгуулалтыг дагасан хот маягийн амьдрал эрчимтэй хөгжсөн юм.


6.2.1. Сумын төвийн эзэмшил газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Тус сумын төвийн газрыг бүхэлд нь хамруулан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг нүүрс олборлох зориулалтаар 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 30 жилийн хугацаатайгаар Эйкүсора гэдэг компанид олгосон байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар Эйкүсора ХХК болон Шивээговь сумын хооронд үүссэн маргаанаа геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах нь зүйтэй. Мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.3, 62.4 дахь заалтуудад Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд тусгагдсан маргаантай талбайнууд хоорондоо ямар нэг байдлаар давхцаж байгаа эсэхийг шалгах бөгөөд давхцал байгаа нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн анхны өргөдөл болон талбайн хилийн хэмжилтийн тайланг үндэслэн талбайн хил, булангийн цэгийн солбицлууд зөв бүртгэгдсэн эсэхийг шалгаж давхцал байгаа нь тогтоогдвол төрийн захиргааны байгууллага сүүлд авсан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд зохих өөрчлөлтийг оруулж, давхцалыг арилгадаг байна.

Мөн түүнчлэн Шивээговь сумын удирдлагууд Эйкүсора ХХК-тай зөвшилцөн тохиролцсоны үндсэн дээр дээрх хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт зааснаар Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг энэ зүйлд заасан журмын дагуу өөрийн хүсэлтээр нь буцаан өгүүлэх арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй.

Бид доорх зурагт Шивээговь сумын төвийн эзэмшил газрыг ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлөөс чөлөөлөхөөр төлөвлөж, зурагт буулгалаа.



Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2013 онд “Нарт дизайн” ХХК гүйцэтгэсэн байна.

Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хугацаанд орон сууцны барилгын нөөцийг 2017 оныхоос нэмэгдүүлэх, нэг хүнд ногдох сууцны талбайг 12 м² хүргэх, соёл ахуйн барилгын хувьд хуримын ордон, банк, олон нийтийн байгууллага, соёлын төв, сургалтын төв, орон нутаг судлах музей зэргийг нэгж хүнд 20 м³ хүргэх, худалдааны барилга, байгууламж 7, үйлдвэр, аж ахуй газруудын хувьд мах, махан бүтээгдэхүүний цех, жимс, хүнсний ногоо савлах, даршлах үйлдвэр, оёдлын үйлдвэр, ноосны үйлдвэр, барилгын материалын үйлдвэр байгуулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэхээр тусгаж байна.

Орон сууц: Тус суманд ажиллаж амьдрах тохилог орчин бүрдүүлэх зорилгоор инженерийн нэгдсэн хангамжид холбогдсон 5 давхар 1.3 мян өрхийн нийтийн тохилог орон сууцуд төлөвлөсөн. Хаус буюу амины орон сууцны хэлбэрийг төлөвлөсөн ба энд 0.36 мян хүн ам оршин суух боломжтой мөн сууцны нийтлэг хэлбэр болох гэр сууц болон байшин сууцны хорооллыг инженерийн шийдэлтэй төлөвлөгдсөн гэрийн хороололд 0.44 өрх айл хамрагдана. Төлөвлөлтийн хугацаанд нийтийн орон сууцны хангамж 75 буюу одоогийн түвшинээс 10 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Хүснэгт 57. Орон сууцны хэрэгцээ, хэтийн төлөв

1	Нийтийн орон сууц	Хүн	1801	4140	8250
2	Өрх	Өрх	565	1035	2200
3	Амины орон сууц	Хүн	113	700	1430
4	Өрх	Өрх	42	175	360
5	Гэр сууц	Хүн	841	1660	1320
6	Өрх	Өрх	322	300	440

Эх сурвалж: Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2013 он

Хүснэгт 58. Орон сууцны төлөвлөлт

БТ дугаар	Орон сууцны хүчин чадал	Давхарын тоо	Тоо ширхэг	Нийт өрх	Сууцны талбай М ²	Шаардагдах хөрөнгө оруулалт \$
Эхний ээлж /2018-2022он/						
61	60 Айлын орон сууц	5	1	60	4620	2254.56
61	30 Айлын орон сууц	5	2	60	5220	2547.4

62	60 Айлын орон сууц	5	1	60	4620	2254.56
62	30 Айлын орон сууц	5	2	60	5220	2547.45
54	75 Айлын орон сууц	5	1	75	7237.5	3531.90
57	75 Айлын орон сууц	5	4	300	29550	14420.43
60	75 Айлын орон сууц	5	1	75	7237.5	3531.91
69	40 Айлын орон сууц	5	6	240	23232	11337.2
	Нийт		15	930	86937	42425.41

Эх сурвалж: Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2013 он

Соёл, ахуйн үйлчилгээ: Соёл, ахуйн үйлчилгээний хангамжийн түвшнээр Дунд гэсэн үнэлгээ авсан бөгөөд төлөвлөлтийн соёл, ахуйн үйлчилгээний хэрэгцээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хот төлөвлөлтийн нормийн дагуу хүн ам, үйлчлэх хүрээний хүн ам буюу хөдөөгийн хүн амын хэтийн төлвөөр авч тооцож үзүүлэв.

Хүснэгт 59. Засаг захиргаа, олон нийтийн байгууллага

Барилга байгууламж	Давхарын тоо	Хэмжих нэгж	Шаардагдах хүчин чадал	Талбай м ²	Ойролцоо хөрөнгө оруулалт \$
			2022 он		
Нутгийн удирдлагын ордон	2	Объект		3250	1677.0
Нийгмийн даатгал	2	Объект		240	147.5
Цагдаагийн байгууллага	2	Объект		350	215.5
Хуримын өргөө	2	Объект	+	580	356.6
Холбоо	2	Объект		240	147.6
Шинжлэх ухаан мэдээлэл	2	Объект		960	590.3
Бизнес мэдээлэлийн төв	2	Объект		845	519.6
Банк	1-2	Объект	+	1200	99.9
Оффис олон нийтийн байгууллага	1-2	Объект	+	680	418.2
Соёлын төв	2	Суудал	+	600 хүний суудалтай	516.5
Сургалтын төв	1-3	Объект	+	1250	768.6
Хүүхдийн ордон	2	Объект		240	147.6
О/Н музей- үзэсгэлэнгийн танхим	1-2	Объект	+	580	356.6
Нийт					5961.5

Эх сурвалж: Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2013 он

Сумын төвийн соёл ахуйн үйлчилгээний барилгуудыг төлөвлөхдөө тухайн суурингийн үйлчлэх хүрээний хүн амын хэрэгцээ хэтийн төлөв болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хот төлөвлөлтийн норм, дүрэм захиалагчийн санал, зах зээлийн хэрэгцээг үндэслэлээ. Хүн амд соёл ахуйн үйлчилгээг аль болох ойр байлгах

зорилгоор өдөр тутмын үйлчилгээг 300-500 м-ийн үйлчилгээний хүрээнд үйлчлэхээр тооцов.

Хүснэгт 60. Худалдаа нийтийн үйлчилгээний байгууллага

Барилга байгууламж	Давхарын тоо	Хэмжих нэгж	Шаардагдах хүчин чадал	Талбай м2	Ойролцоо хөрөнгө оруулалт \$
			2022 он		
Бөөний болон худалдаа үйлчилгээний төв төвүүд	1-2	Объект	+	4000	4128.2
Хүнс, барааны зах	1-2	Объект	+	3525	3127.6
Зочид буудал	1-2	Объект	+	2589	1676.9
Ресторан	1-2	Объект		965	1161.6
Халуун ус, саун	1	Объект	+	120	52.7
Ахуй үйлчилгээний төв	2	Объект	+	482.5	275.8
Дэлгүүр	1-2	Объект	+	425-600	206362
Нийт					6810.5

Эх сурвалж: Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2013 он

Худалдаа үйлчилгээний байгууллага: Хүн амын хэрэгцээнд шаардагдах худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн төрийн бус байгууллагын контор энгийн болон дээд зэрэглэлийн зочид буудал төлөвлөлтөнд тусгасан болно.

Үйлдвэр цех: Мах махан бүтээгдэхүүний үйлдвэр, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, жимс-хүнсний ногоо савлах даршлах үйлдвэр, оёдлын үйлдвэр ноосны үйлдвэр төлөвлөсөн.

Талх нарийн боовны цехүүдийг худалдаа үйлчилгээний төвүүдэд нэгэн дээвэр дор байдлаар төлөвлөх нь эдийн засгийн ач холбогдолтой. Үйлдвэр аж ахуйн зориулалттай нөөц талбайд зөвшөөрөгдөх үйлдвэр цехүүдийг байгуулж болно.

Эдийн засаг-жижиг дунд үйлдвэрлэл: Шивээговийн цаашдын нийгэм-эдийн засгийн хөгжилд шинэ үйлдвэрлэл үйлчилгээ бий болгож, хүн амын бизнесийн идэвх чармайлтыг нэмэгдүүлэхэд оршино. Эдийн засгийн үндсэн салбар нь нүүрс олборлолт, хөдөө аж ахуй болно. Мөн барилгын материалын үйдвэрлэл, нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц түүхэн үйл явц монгол ахуйд түшиглэсэн аялал жуулчлалын маршрут бий болгон хөгжүүлж болно. Уул уурхайн салбарын хөгжил гэхээсээ илүүтэйгээр тухайн салбарыг дагуулж жижиг дунд бичил бизнесийг хөгжүүлэх нь эдийн засгийн хүчирхэг бааз суурь болж чадахгүй ч тухайн орон

нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц өсөлтийг бий болгох ач холбогдолтой.

Хүснэгт 61. Үйлдвэр аж ахуйн газрууд

Барилга байгууламж	Давхарын тоо	Хэмжих нэгж	Шаардагдаг хучин чадал	Ойролцоо хөрөнгө оруулалт \$
			2018-2022	
Мах махан бүтээгдэхүүний цех	1	Объект	+	122.0
Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	1			73.2
Жимс-хүнсний ногоо савлах даршлах үйлдвэр,	1	Объект	+	94.1
Оёдлын үйлдвэр	2	Объект	+	190.8
Ноосны үйлдвэр	1	Объект	+	167.5
Барилгын материалын үйлдвэр	1		+	275.6
Нийт				923.2

Эх сурвалж: Шивээговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2013 он

6.2.1.1. Газар ашиглалтын бүсчлэл, түүний зориулалт


Батлагдсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвийг эрчимтэй хөгжүүлэх зарчим баримтлах ба сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2018-2022 оны хугацаанд Шивээговь сумын төвийн нутаг дэвсгэрийг газар ашиглалтын нийтлэг хэлбэр болон онцлогоос хамааран дараах бүсүүдэд хувааж ойрын 5 жилд энэхүү бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Үүнд:

1. Орон сууцны бүс
2. Сургууль цэцэрлэгийн бүс
3. Худалдаа уйлчилгээ, ногоон байгууламжийн бүс
4. Үйлчилгээ, амралт зугаалгын бүс
5. Үйлдвэрийн бүс
6. Авто машины дулаан зогсоол
7. Гэр хороололын бүс-1
8. Гэр хороололын бүс-2
9. Гэр хороололын бүс-3
10. Шатахуун тугээх станцын бүс

Эдгээр бүсүүдийн газрын хэмжээ, газар эзэмшүүлэх, ашиглуулах зориулалт, ашиглах хугацааг тус бүрт нь төлөвлөж доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 62. Газар ашиглалтын бүс, түүний зориулалт

Газар ашиглалтын бүс	Газрын хэмжээ /га/	Бүс дотор эзэмшүүлж, ашиглуулах газрын зориулалт	Ашиглах хугацаа /он/
Орон сууцны бүс	14	Хаус буюу амины орон сууц	2018
Сургууль цэцэрлэгийн бүс	9	Сургууль, цэцэрлэг барьж байгуулах, өргөтгөх	2019
Худалдаа уйлчилгээ, ногоон байгууламжийн бүс	16	Хүн амын хэрэгцээнд шаардагдах худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн төрийн бус байгууллагын контор энгийн болон дээд зэрэглэлийн зочид буудал	2019-2020
Үйлчилгээ, амралт зугаалгын бүс	19	Хотын чанартай цэцэрлэгт хүрээлэн, тусгай зориулалтын цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамж, цэцэрлэгт талбай	2020-2021
Үйлдвэрийн бүс	31	Дулааны цахилгаан станц, Мах махан бүтээгдэхүүний үйлдвэр, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, жимс-хүнсний ногоо савлах даршлах үйлдвэр, оёдлын үйлдвэр ноосны үйлдвэр	2018-2019
Авто машины дулаан зогсоол	6	Авто зогсоол, авто машины дулаан гараш	2018
Гэр хороололын бүс-1	113	Гэр хашааны газар, өрхийн эмнэлэг, халуун ус, худаг усан сан, үйлчилгээний төв, түлээ нүүрс борлуулах цэг	2018
Гэр хороололын бүс-2	95	Энэ бүсэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд газар өмчлүүлэх	2019
Гэр хороололын бүс-3	169	Энэ бүсэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд газар өмчлүүлэх	2018-2020
Шатахуун тугээх станцын бүс	8	шатахуун түгээх станц	2018
Эрчимжсэн маа бүс	1	Энэ бүсэд сүүний үхрийн эрчимжсэн фермерийн зориулалтаар олгох	2019



Хог хаягдал.

Хогийн цэг нь хаягдлыг хүлээн авч ангилан ялгалт, боловсруулалтын ажил хийгдээгүй. Хогийн цэгийн талбай хотын баруун талаас суурьшил тал руугаа ихээхэн газар авч байна. Шинээр байгуулах хог боловсруулах үйлдвэр хотын суурьшилд хэт ойр байгаа нь цаашид сумын төвийн суурьшил тэлэхэд энэ сонгосон хогийн цэгийн байршил төдийлөн тохиромжтой биш юм. Энэ байдлаас үүдэж хог боловсруулах үйлдвэрийг одоо байгаа хогийн цэгээс цааш баруун урд талд байршуулах нь зүйтэй. Хог хаягдлыг анхан шатны цэгээс цуглуулах 2 тогтолцоо байдаг.

Эхний хувилбар нь: Хог хаягдлыг айл өрхөөс шууд ачиж хогийн цэгт хаях юм. Ингэхдээ хогийг анхан шатнаас нь ангилан ялгалт хийлгэсний дүнд айл өрхөөс ачих юм. Гол нь ард иргэдэд уг ажлыг ойлгуулж улмаар ангилан ялгасан хоёрдогч түүхийг эдийг худалдан авах, хэрэгжүүлэхэд өртөг зардлын хувьд боломжийн хувилбар юм.

Дараагийн хувилбар нь: Айл өрхөөс хогийг шууд ачаад дунд нь ангилан ялгалт хийх юм. Ангилан ялгалт хийх байгууламж нь бага оврын хог боловсруулах цех буюу үйлдвэр байх ба төлөвлөлт хийж буй суурьшлуудын захад эсвэл хог хаях хогийн цэгийн дэргэд байвал хамгийн тохиромжтой байрлал юм. Энэ цех, үйлдвэр нь хогийн цэгт байршсанаар өмнөх түүхий эд, ойр орчмын сумдын хогийг бас ашиглах боломжтой. Өртөг зардлын хувьд хөрөнгө ихээхэн шаардагддаг.

Хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөөг ээлж дараатай боловсруулж, ариун цэврийн шаардлага хангасан ландфиллийн аргаар суурьшлаас гарсан хатуу хог хаягдлыг олон улсын стандартын түвшинд устгадаг болох нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Суурьшлаас гарах хогний хэмжээг нэг хүнд жилийн хугацаанд 190-220 кг, бохир усыг 900-1000 летр байхаар тооцож төлөвлөв. Ингэхэд эхний ээлжинд 15000 тн, төлөвлөлтийн хугацаанд 30000 тн хог хаях урьдчилсан тооцоо гарч байна.

Цаашид орон нутгийн зүгээс тухайн суурьшлын онцлогт тохирсон хог хаягдлыг ангилан ялгах, худалдан авах тусгай журамын боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй. Цаашид хог хаягдлыг багуудаас хэрхэн ялгавартай байх төсөөллийг дараахь зургаас үзнэ үү.

Эхний ээлжинд 10000 тн, төлөвлөлтийн хугацаанд 12000 тн хаягдал ялгаж хоёрдогч түүхий эд болгохоор тооцов. Ангилан ялгагдахгүй хогийг хотоос зүүн урд зүгт байршуулж нэгдсэн зохион байгуулалттайгаар хогийн цэгт булж дарах, гэрчилгээжүүлэх ажлыг үе шаттай боловсруулах, түүхий эд бэлтгэх нь зүйтэй.

Шинэ суурьшлын гарах хогны хэмжээг суурьшилтай хамт тооцсон бөгөөд гарах хогийг мөн одоо байгаа төвлөрсөн хогийн цэгт хаяхаар тооцлоо.

6.2.2. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын төлөвлөлт

1. Төрөлжсөн аялал жуулчлал хөгжүүлэх боломж

Тус аймагт аялал жуулчлалын олон төрлийн үйл ажиллагаа хөгжүүлэх боломжтой.

Фото сафари буюу байгалийн гэрэл зураг авах аялал: Байгаль, түүхийн өвөрмөц сонин тогтоц, үзэсгэлэнт хослол, ховор амьтан, ургамал, хүн байгалийн зохицол фото зураг сонирхогчдын анхаарлыг зүй ёсоор татдаг.

Нүүдэлч малчдын соёлтой танилцах аялал: жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг нүүдэлч малчдын ахуй, зан заншил

Байгаль, түүх сонирхогчдын аялал: заримдаг цөл, хуурай хээр, элс манхан бүхий онгон байгалийн гоо үзэсгэлэн бүрдсэн зэлүүд орчинд аялж аргаль, зэрэг зэрэг дэлхийд ховордсон ан амьтан, шувууд, сонин зүйлийн ургамал, шавьж харах боломжтой. Мөн тус аймагт элбэг тохиолдох шашин шүтлэгийн объектууд, хадны зураг, буган чулуу, хүрэл зэвсгийн үеийн булш, чулуун хөшөө мэтийн түүх археологийн дурсгалт зүйлсийг сонирхож болно.

Ердийн хөсгийн аялал: Морь, тэмээн аялал зохион байгуулах боломжтой. Гадаад дотоодын жуулчдын ихээхэн сонирхдог аялал жуулчлалын нэгэн төрөл бол ердийн хөсгийн аялал юм. Нэн ялангуяа онгон зэлүүд тээврийн хэрэгслээр хүрэх боломжгүй газруудаар аялахад чухал үүрэгтэй. Нөгөө талаар үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалтай танилцахад ихээхэн боломж олгодог, цашилбал хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлдэггүй зэрэг давуу талтай.

Явган аялал: Тус сумын хотгор гүдгэрт гадаргын налуу 30-аас ихгүй тэгш тал зонхилж байгаа нь явган аялал хөгжүүлэхэд тохиромжтой болохыг харуулж байна. Явган аялалын нөөц, хүндрэлийн хувьд жилийн дөрвөн улирлаар нилээд ялгаатай. Өвөл хаврын улирал нь ширүүн хахир болдог учраас явган аялал хөгжүүлэхэд тохиромж муутай. Зун намрын улиралд тохиромжтой. Ийм үеийн үргэлжлэх хугацаа тус аймагт 3 сар үргэлжлэнэ.


Шивээговь суманд аялал жуулчлалын менежментийг сайжруулах, ядуурлыг бууруулах чиглэлээр нутгийн иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэх, орлогын шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор жижиг хамтлагууд байгуулж гар урлалын зүйл хийж жуулчдад худалдах, жуулчдыг байрлуулах гэр ажиллуулах, жуулчдад үйлчлэх зэрэг үйлчилгээ явуулах боломжтой. Аялал жуулчлалын бизнес нь тухайн орон нутагт хөрөнгө оруулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, танин мэдэхүй, харилцааны соёлыг дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлөх боловч зарим сөрөг үр дагавар авчирдаг. Үүнд: жуулчдын хоноглож, отоглосон газруудад хог хаягдал бөөгнөрөх; жижиг гол, горхи, булаг шандын ус бохирдох; эмзэг тогтоцтой газрын хөрс, бэлчээр эвдэрч талхлагдах; агнуураас болж ховор ан амьтдын сүргийн бүтэц тоо толгой өөрчлөгдөх; түлшний хомсдол бий болох, орон нутагт морь унаа, тээврийн хөлсний үнэ ханш өсөх зэрэг сөрөг үзэгдлүүд байгаа бөгөөд тэдгээрээс хамгаалах бүрэн боломжтой.

2. Аялал жуулчлалын бүсүүд

Шивээговь суманд аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газар, хотгор гүдгэр, үзэх зүйлс, хүрэх боломж зэргийг харгалзан аялал жуулчлалын бүсийг ялган тогтоов.

Хүснэгт 63. Аялал жуулчлалын бүс

№	Аялал жуулчлалын бүсийн нэр	Бүсийн хэмжээ /га/
I	Шивээгийн нуур	220



6.2.3. Говьсүмбэр аймгийн нутгийн “Брэнд” бүтээгдэхүүн

Брэнд гэдэг нь хэрэглэгчийн ой тойнд үлдэх онцгой нэгэн санаа эсвэл зарчмыг хэлдэг. Брэнд үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүнийг таних, өрсөлдөгчдөөс нь ялгах нэр, лого, загвар, ямар нэгэн шинж чанар эсвэл эдгээрийн нийлбэр цогц юм. Хэрэглэгчийн хувьд өрсөлдөгч бүтээгдэхүүнээс тодорхой онцлог шинжээр ялгаран хэрэглэгчийн сэтгэлд хоногшиж чадсан бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг илэрхийлдэг.

Одоо байгаа брэндийн нэрийг ашиглан зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах боломжтой. Говьсүмбэр аймгийн брэнд бүтээгдэхүүн бол:

1. Сүмбэр үүлдрийн хонь
2. Шивээ-Овоогийн нүүрс юм. Энэхүү хоёр брэнд бүтээгдэхүүнийг ашиглан бэлэг дурсгалын зүйл бүтээж зах зээлд нэвтрүүлснээр брэнд мөнхөрөх болно.

Говьсүмбэр аймаг нь байгаль-түүх-дурсгал, ан амьтны өлгий нутаг бөгөөд ирээдүйд аялал жуулчлал өргөжин хөгжих хандлагатай байна. Иймээс гадаад, дотоодын аялагч, жуулчид болон ажил хэргийн зочдод зориулан нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчилсан бэлэг дурсгалын зүйлс бүтээж борлуулах нь өрхийн үйлдвэрлэлийг дэмжсэн үйл ажиллагаа болох ба орон нутгийн төсөвт бага боловч хувь нэмэр оруулах нь тодорхой юм.

Сүмбэр үүлдрийн хонины арьсыг ашиглан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаа:



Шивээ-Овоогийн нүүрсийг ашиглан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаа:



Брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөөц, байршил

Д/д	Брэнд бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүний нийт нөөц	2016 онд бэлтгэсэн нөөц	Нөөцийн газарзүйн байршил
1	Сүмбэр үүлдрийн хонины арьс болон ноосон бэлэг дурсгал бүтээгдэхүүн	1595 толгой хонь	316 ширхэг арьс бэлтгэсэн	Сүмбэр сумын 6 дугаар баг
2	Шивээ-Овоогийн нүүрсэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	2708.7 сая тн нүүрс	45.1 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэсэн	Шивээговь сумын Шивээ-Овоогийн нүүрсний уурхай

6.3. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

6.3.1. Авто замын газрын төлөвлөлт

6.3.1.1. Олон улсын чанартай авто замын төлөвлөлт:

2004 онд Засгийн газар хоорондын гэрээгээр Монгол улс Азийн авто замын сүлжээнд холбогдохоор тогтож 2013 оноос олон улсын азийн авто замын сүлжээ АНЗ-/Замын-Үүд-Сайншанд-Чойр-Налайх-Улаанбаатар-Дархан-Сүхбаатар-Алтанбулаг/ чиглэлийн зам барих ажлыг эхлүүлсэн билээ.

"Чингис Лэнд Девелопмент Групп – Шинэ Хөгжлийн Зам" ХХК Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 99, 399 дүгээр тогтоолын дагуу Эдийн Засгийн Хөгжлийн Яамтай "Алтанбулаг–Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам" төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээг 2014 оны 3 дугаар сарын 9-ний өдөр

байгуулсан. Энэхүү мега төслийг Монгол Улсад анх удаа концессийн Барих-Ашиглах-Шилжүүлэх нөхцлөөр гэрээ байгуулсан байна.

Хурдны авто зам нь Монгол Улсын зургаан аймгийн 24 сум, Нийслэлийн 2 дүүргийн нутгийг дайран өнгөрөх бөгөөд нийтдээ 990 орчим км үргэлжлэх томоохон бүтээн байгуулалт болох юм.

Хурдны замын трассыг тогтоож трассын дагуу Алтанбулаг-УБ-Мааньт чиглэлийн 450 км газарт геотехникийн /геодези, инженер-геологи, гидрометеорологи/ суурь судалгаа, Алтанбулаг-Маньт чиглэлийн 450 км хэсгийн зам барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг дуусгах, Мааньт-Замын-Үүд чиглэлийн 550 км хэсгийн геотехникийн суурь судалгааны ажлыг тус тус гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 64. Олон улсын АНЗ чиглэлийн авто замын төлөвлөлт

Хурдны замын нэр	Замын чиглэл	Нийт урт /км/	Говьсүмбэр аймаг дах замын чиглэл	Урт /км/	Хамгаалалтын зурвас /га/
АНЗ	Алтанбулаг-Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Налайх-Чойр-Сайншанд-Замын-Үүд	1041	Налайх-Чойр-Сайншанд	73	1457

6.3.1.2. Улсын чанартай авто замын төлөвлөлт:

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэх чухал хөшүүргийн нэг нь авто замын сүлжээг өргөтгөх асуудал бөгөөд аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар холбож, аймаг орон нутаг хоорондын нийгэм, эдийн засгийн харилцааны таатай орчинг бүрдүүлэхээр Чойр-Мандалговийн чиглэлд шинээр баригдах улсын чанартай нийт 184 км авто замын Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дайран гарах 31 км замын чиглэлийг, Чойр-Өндөрхаан чиглэлд шинээр баригдах нийт 225 км авто замын 38 км замын чиглэлийг тус тус төлөвлөгөөнд тусгав.

Хүснэгт 64. Шинээр баригдах улсын чанартай авто замын төлөвлөлт

Авто замын	Авто замын чиглэл.	Замын	Хэрэгжих	Замын урт /км/	Замын
------------	--------------------	-------	----------	----------------	-------

чиглэл	/холбогдох хот, суурин, ордууд, хатуу хучилттай замын нэр/	ангилал, зориулалт	хугацаа	Нийт	Говьсүмбэр аймаг дахь замын урт	хамгаалалтын зурвасын хэмжээ /м/
Сүмбэр/Чойр/-Мандалговь	Сүмбэр/Чойр/-Шивээ-Овоо-Говь-Угтаал-Их газрын чулуу жуулчны бааз-Мандалговь	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	184	31	100
Сүмбэр/Чойр/-Өндөрхаан	Бор-Өндөр-Дархан-Баянмөнх-Өндөрхаан	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	225	54	100

*Эх сурвалж. Авто зам тээврийн салбар 2018-2020 онд: Зам тээврийн хөгжлийн яам/

Хүснэгт 65. Төлөвлөсөн авто замын маршрутыг тохиромжтой байдлын үнэлгээтэй давхацуулан үнэлсэн байдал, авто замын зурвас газрын хэмжээ

Д/д	Аймгуудын нэр	Эхлэх-төгсөх /км/	Тохиромжтой байдлын үнэлгээ				
			Замын доорхи газар /га/			Зурвас газар /га/	
			Нэн хүнд - рэлтэй	Хүнд-рэлтэй	Хэвийн	Нэн хүнд-рэлтэй	Хүнд-рэлтэй
1	Трассын нийт 338км-с 28км буюу 8.3% нь нэн хүндрэлтэй, 45км буюу 13.3% нь хүндрэлтэй, 265км буюу 78.4% нь хэвийн нөхцөлтэй						
32	Говьсүмбэр.Сүмбэр/Чойр/-Хэнтий.Өндөрхаан 2020-2024	225			269.3		2245.1
	Трассын нийт 225км зам нь 100% нь хэвийн нөхцөлтэй						
33	Говьсүмбэр.Сүмбэр/Чойр/-Дундговь.Мандалговь 2020-2024	0-82			98.8		824.1
		82-92	11.5			96.1	
		92-135			51.8		432.3
		135-165		35.4			295.4
		165-184			22.4		187.5

6.3.1.3. Орон нутгийн чанартай авто замын төлөвлөлт:

Улсын чанартай А01 чиглэлийн авто замтай Шивээговь сумын төвийг 8 км урт замаар холбохоор төлөвлөлөө.

Хүснэгт 66.

№	Сумын нэр	Замын урт /км/	Төсөв зардал	Хэрэгжүүлэх хугацаа
1	ШивээГовь	8		2018-2019
	Бүгд	8		

6.3.1.4. Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдах авто замын төлөвлөлт:

Аймгийн нутаг дэвсгэр дэхь байгаль, түүх дурсгал бүхий газрыг түшиглэн томоохон амралт сувилал, аялал жуулчны бааз байгуулж болохуйц байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай нь холбогдох байгууллагаар тогтоогдсон зам харилцаа, гэрэл цахилгаан, ундны усны эх үүсвэртэй хямд өртгөөр холбогдох боломжтой газрыг хамруулан аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс газрыг дараах 4 байршилд тогтоосон байна. Үүнд: **Хөшөөтийн хүн чулуу-Чингэлийн хадны хиргисүүр-Хүрий ногоон-Чойрын богд-Шивээгийн нуур**

Эдгээр аялал жуулчлалын бүсэд хүрэх маршрутыг аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/334 тоот захирамжаар тогтоожээ.

Бид энэ ажлынхаа хүрээнд аялал жуулчлалын маршрутыг газар зүйн мэдээллийн системийн Arc Gis програм ашиглан орон нутгийн зам дагуу зураглаж, уртын хэмжээг тооцоолж үзэхэд ойрын зайн маршрут 91 км, дундын зайн маршрут 144 км, холын зайн маршрут 180 км байна. Зураг


6.3.2. Эрчим хүчний шугам, сүлжээний төлөвлөлт:

Тус аймаг нь төвийн эрчим хүчний системд холбогдсон, аймгийн төвдөө Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан дамжуулах станц байрлаж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цахилгаан хангамж сайтай аймаг юм.

Цаашид уг дамжуулах станцаас Багануур-Чойр, Чойр-Сайншанд, Чойр-Цагаансуварга, Чойр-Цайдамын чиглэл тус бүрт 220 квт-ын 2 хэлхээ нийт 124 км урт эрчим хүчний шугам тавихаар төлөвлөлөө.

Хүснэгт 67. Цахилгаан дамжуулах шугам, сүлжээний төлөвлөлт

№	Чиглэл	Хүчин чадал	Урт /км/	Хэрэгжих хугацаа
1	Чойр-Сайншанд	220квт	33	2019-2022
2	Чойр-Цагаансуварга	220квт	43	2019-2024
3	Чойр-Цайдам	220квт	48	2018-2021



6.4. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Говьсүмбэр аймаг нь усан хангамжын хувьд хангалттай биш ба аймгийн хэмжээнд цөөн тооны булаг, шанд, гол горхи нь ундрага багатай.

Ус зүйн сүлжээний хувьд аймгийн нутаг дэвсгэрийн багахан хэсэг нь (нутгийн зүүн хойно Хэрлэн голын сав) номхон далайн ай савд үлдсэн хэсэг нь төв азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг.

6.5.3. Нуур:

Шивээ-Овоогийн уурхайн шүүрүүлгийн уснаас бий болсон Шивээгийн нуур нь хүний гараар бүтсэн үзэсгэлэнт газрын нэг болж аймгийн төдийгүй гадаад, дотоодын жуулчдын амарч зугаалах аятай нөхцөлийг бүрдүүлсэн газар болжээ. Мөн нуураас суваг шуудуу татаж усалгаатай газар тариалан эрхэлж, төмс, хүсний ногоо тарьж ургуулж байна. Шивээгийн нууранд бух, сугас загас үржиж байгаа бөгөөд спорт загас агнуурыг хөгжүүлэх боломжтой юм.

Уурхай жилд 4 сая шоо метр усыг газрын гүнээс татаж төмөр хоолойгоор нууранд цутгаж байна. Газрын гадарга усны элэгдэлд нилээд их орж, ганга жалга үүссэн байдалтай байна. Нуурыг зорин ирж буй амрагч, аялагчдын аюулгүй байдал болон газрын гадаргын элэгдлийг тэлэхгүй байх үүднээс жалгаар ус урсах ёроол хэсгийг бетоноор доторлож, цаашид усанд идэгдэж гүнзгийрэхээс хамгаалах, жалгын эргийн нуралтаас урьдчилэн сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Цаашид нүүрсний 1, 2-р давхаргын шургах чигт усжилт нэмэгдэх гидрологийн нөхцөлтэй. Иймээс нуурын орчимд ёроолын болон эрэг хавийн шингэлт, ууршлын ажиглалтыг зохих журмын дагуу хийх нь шүүрлийн бүсэд хиймэл нуур тогтмол тэжээлтэй хил үүсгэдэг эсэхийг үнэлэх боломжтой болно. Нуурын эзлэх талбай нэмэгдэж ойр орчмын тариалангийн талбайд хүрэх магадлалтай байна. Иймээс нуурын усны горимыг тохируулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

Долдугаар бүлэг. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

Монгол улсын нутагт ЗХУ (хуучин нэрээр)-ын цэргийн ангиуд 1966 оны 7 дугаар сараас 1992 оны 12 дугаар сарыг дуустал байрлаж байсан. Эдгээр цэргийн ангиуд тус улсын нутагт байрлаж байх хугацаандаа газрыг контор, орон сууц, ахуйн үйлчилгээ, шатах тослох материал хадгалах зэрэг төрөл бүрийн зориулалтаар барилга, байгууламж барих, сургуулийн талбай, нуувч байгуулах, замаар ашиглаж байсан байна.

1990-ээд оны сүүлчээр Орос цэргийн анги нүүсэн цагаас эхлэн орон нутгийн иргэд эзэнгүй орхигдож үлдсэн барилга байгууламжийг нураан авснаар нурсан барилгын суурь, ухмал нүх мэтийн хатуу хог хаягдал ихээр үлдэж орчныг механик бохирдолоор бохирдуулсан байна.



Цэрэг, батлан хамгаалах зориулалтаар ашиглаж, эвдрэлд орж орхигдсон 10 хэсэг газарт нийт 27.5 га талбайд хамаарах 89571.25 м³ хог хаягдлыг цэвэрлэж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх техник эдийн засгийн үндэслэлийг Байгаль орчны үнэлгээ, зөвлөгөөний “Санни трейд” ХХК боловсруулсаныг эх сурвалж болгон ашиглав.

Хүснэгт 68. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд хамрагдах талбай, хог хаягдлын хэмжээ

№	Ямар зориулалтаар ашиглагдсан	Нөхөн сэргээх талбай, га	Талбайн хог м ³	Тайлбар
1	Цэргийн анги	10.95	41944.2	
2	Командын байр	0.12	1959, 1	
3	Буудлагын бай	0.32	-	Нөхөн сэргээж ашиглаж байгаа
4	Цэргийн ангийн хотхон	6, 5	13093.0	
5	Цэргийн анги 2	8	24328.3	
6	Усны шугамын ухмал	1, 6	8246.65	
Дүн		27.5	89571.25	

Дээрхи объектуудын нөхөн сэргээх чиглэлийг тогтоож, цаашид аж ахуйн эргэлтэд ашиглах саналыг талбарт тус бүрээр орууллаа. Үүнд:

Цэргийн анги

Цэргийн анги нь 2 хэсэг томоохон хэмжээний талбайгаас бүрдсэн 10.95 га талбайтай нурсан барилгын хаягдал бүхий нийт 41944.2 м³ хог хаягдлын үлдэгдэл байна.



Зураг 11. Цэргийн ангийн талбайн эвдэрсэн байдал

Цэргийн ангийн барилга, байгууламжын үлдэгдэл хана болон түүний орчим хаягдсан барилгын хог хаягдал, нураасан байшингийн тоосго, цементэн хийцийн хогийг цэвэрлэж, бөөгнүүлэн нэгдсэн журмаар ачиж тусгайлан бэлдсэн овоолгын талбайд тээвэрлэн хаях нь зүйтэй.

Командын байр

Командын байр нь 1 хэсэг 2 жижиг байшингийн хог 1 томоохон овоолгоос бүрдсэн 0.12 га талбайтай 1959.1 м³ хог хаягдлын үлдэгдэлтэй байна.



Зураг 13. Командын байрны одоогын төлөв

Командын байрны барилгын хог хаягдал, нураасан байшингийн тоосго, цементэн хийцийн хогийг цэвэрлэж, бөөгнүүлэн нэгдсэн журмаар ачиж тусгайлан бэлдсэн Овоолгын талбайд тээвэрлэн хаях нь зүйтэй.

Буудлагын бай

Буудлагын бай нь 0.32 га талбайтай нөхөнсэргээж ашиглаж байна.



Зураг 14. Буудлагын бай

Цэргийн ангийг хотхон

Цэргийн ангийн хотхон нь 6.5 га талбайтай нурсан барилгын хаягдал бүхий нийт 13093.0 м³ хог хаягдлын үлдэгдэл байна.



Зураг 17. Цэргийн анги 2-н одоогын төрх

Цэргийн ангийн усны шугам

Цэргийн ангийн усны шугум нь 2 хэсэг газарт хамаарагдах 1.6 га талбайтай 8246.65 м³ хог хаягдалтай байна.



Усны шугамаас үүссэн овоолгыг тэгшилж янзлан хог хаягдлыг нь цэвэрлэж тусгайлан бэлдсэн овоолгын талбай руу тээвэрлэж хаях нь зүйтэй.

Нөхөнсэргээлт хийх арга хэмжээний төлөвлөгөө

Нийт зайлуулах хог хаягдлын хэмжээ

Сийрэгжилт тооцоогүй хог хаягдлын эзэлхүүн нь 89571.25 м³ (Энэ нь газрын дээрхи хог хаягдал болно)

Тээвэртэй ашиглалтын системээр зөөвөрлөн овоолго үүсгэх ба нийт хог хаягдлын хэмжээ 89571 м³ байна. Хог хаягдлын 30 хувь болох 26871.3 м³ хог хаягдлаар хоосон орон зайг дүүргэх, үлдсэн 70 хувийг овоолго болгон тэгшлэх, хэлбэршүүлэхээр тооцжээ.

Хог хаягдлын овоолго

Хог хаягдлын овоолго үүсгэх талбайг урьдчилан сонгож талбайг бэлтгэнэ. Овоолго үүсгэх ажилбар нь хөрс хуулалт, орчны хог хаягдлын цэвэрлэгээний технологийн дамжлагын эцсийн шат болно. Овоолго нь газрын эвдрэлийн үүсмэл өндөршлийг бий болгох бөгөөд овоолгыг шовх, нуруулдсан, дугуй, хавтан хэлбэртэй гүйцэтгэнэ. Овоолгын дор дарагдах талбайг багасгах үүднээс овоолгын өндрийг тохиромжтой хэмжээнд хүртэл өндөрсгөн байгуулж, хажуу налууг нь хэвгийжүүлэх, дэвсэгжүүлэх замаар тогтворшлыг хангана.

Овоолгын хэлбэр, хэмжээс нь ашиглах зориулалт, нөхөу сэргээлт хийх технологи, техник тоног төхөөрөмжийн овор хэмжээ зэргээс хамаарна. Гадаргын хэлбэрийн чухал бүрэлдэхүүн хэсэг бол хажуу, өндөршил, чиглэл болон ус шүүрэлтийн нягтрал юм. Өөрөөр хэлбэл нөхөн сэргээх үеийн гадаргын хэлбэр нь хожим овоолгыг хэлбэршүүлэн налуу, өндөршилтийг тогтооход суурь үзүүлэлт болдог.

Овоолгын хажуугийн налуу 230-аас доош бол овоолго тогтворшил сайтай байна. Овоолгын хэлбэр нь орчинтойгоо зохицсон, цаашид ашиглах зориулалтад тохиромжтой, налуугийн өнцөг нь стандартын шаардлагад (*Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917 : 2008*) нийцсэн байх ёстой.

Овоолгын налуугийн өнцөг нь 11-170 бол дэвсгийн өргөний дээд хэмжээ 50-30 м байна. Овоолгын налуугийн гадаргыг дан хотгор хэлбэрээр хийж болохгүй. Налуугийн уналт гүдгэрээс хотгорт шилжсэн долгиолог хэлбэртэй байна. Газрын дотор талд 50 м /дундаж зай/ зайд, дундажаар 2.5 м өндөртэйгээр овоолго хийнэ.

Ухашын нөхөн дүүргэлт ба овоолго

Иргэдийн ухаж, нурааж авсан барилга байгууламж, цэвэр, бохир усны шугам хоолой, кабелийн ухсан шуудуу, барилгын подволь болон бусад ухмал нүх зэрэг хоосон

орон зайг нөхөн сэргээж, дүүргэлт хийхдээ ойр орчмын хог хаягдлыг бульдозороор түрэх, хол хэсгийг авто тээврээр хамгийн ойр зайд зөөвөрлөн хоосон орон зайг дүүргэх замаар нөхөн дүүргэлт хийнэ. Харин үлдсэн хэсгийг сонгож авсан талбайд овоолго байгуулах замаар шийдвэрлэнэ.

Хүнд даацын автотээврийн хэрэгслээр зөөж, бульдозороор түрж овоолго үүсгэх замаар техникийн нөхөн сэргээлт, ухашийн дүүргэлт хийхдээ тээврийн зай, замын уруу, өгсүүр, эргэх болон буулгах талбай, овоолго байгуулах орон зайн багтаамж зэргээс хамруулан зохион байгуулна.

Талбайн хувьд ашигласан хоосон орон зайг орчны хог хаягдлаар дүүргэж, бульдозороор түрж шороогоор нь эргүүлэн булж дүүргэн, хөрсийг сайжруулснаар талбайг ургамалжуулах нь зүйтэй.

Цэрэг батлан хамгаалахын зориулалтаар ашиглагдаж эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг янз бүрийн хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

Хүн болон малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн засаг захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий (налуу) ихтэй (180-аас их) юмуу хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налууугын эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

1.Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Мандалговь хот орчмын нутаг нь хуурай хээрийн ба говийн бүсийн хил заагт орших талархаг гадаргатай газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж

өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй авах шаардалагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут, сөөг, модлог ургамал орлцсон ойн зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалтыг хийх зэрэг арга хэмжээг авна.

Монгол орны хэмжээнд хуурай хээр, говь, цөлийн бүс нутгийн хөрсний гадарга нь нэлэнхүйдээ жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байдаг бөгөөд энэ хөрсийг хүчтэй салхинд хийсэхгүй байх нөхцөл болж байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийж дууссан газрыг 2-10 мм хэмжээтэй жижиг сайр чулуугаар 1-2 см зузаантай хучилт хийж өгвөл хөрсний нунтаг шороон хэсэг нь хийсч алдархаас хамгаалах боломжтой.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Шивээговь сумын хэмжээнд цэрэг, батлан хамгаалах зориулалтаар ашиглаж, эвдрэлд орж орхигдсон газрын тооллого хийж, техник эдийн засгийн үндэслэл боловсруулсан ажлын үр дүнг үндэслэн дараахи санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Цэрэг, батлан хамгаалах зориулалтаар эвдэгдэж орхигдсон газруудад хаягдаж үлдсэн дарьтай бууны сум, хонгио, цэнэгтэй, цэнэггүй тэсрэх бөмбөг (мина) болон бусад тэсрэх хэрэгслүүд их хэмжээгээр ил хаягдсан, газрыг ухаж энд тэндгүй тарсан байдалтай байна.
- Тиймээс батлан хамгаалах зориулалтаар ашиглаж байсан бүх газрыг нөхөн сэргээлт хийхийн өмнө цэнэгтэй, цэнэггүй тэсрэх бөмбөг, сум, хонгио болон бусад тэсрэх байлдааны хэрэгслүүдийг мэргэжлийн байгууллага аюулгүй болгон цэвэрлэх зайлшгүй шаардлагатай юм.
- Нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ эхний үе шатанд байлдааны хэрэгслээс цэвэрлэн, аюулгүй болгосноор техникийн нөхөн сэргээлтийг эхлэнэ. Техникийн нөхөн сэргээлтэд хатуу хог хаядлыг тусгайлан бэлтгэсэн овоолгод зайлуулах, ашиглагдсан орон зайг нөхөн дүүргэх, ухаш болон овоолгын гадаргууг хэвгийжүүлэн тэгшлэх, нийт талбайг тэгшлэх, тэгшилсэн хөрсийг нягтаршуулах, хөрс боловсруулах, сайжруулах ажлыг гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлтэд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг ургамалжуулах, мод, сөөг тарина. Харин нөхөн сэргээлтийг гүйцэтгэж дууссаны дараа цаашид нөхөн сэргээлтийн дараах хяналт-шинжилгээг хийх зэрэг үе шаттайгаар

гүйцэтгэх нь зүйтэй.

- Цэрэг, батлан хамгаалах зориулалтаар эвдэгдсэн газрын барилгын зарим үлдэгдлийг бөөгнүүлэн овоо, хиймэл толгой үүсгэж хөрсөөр хучин ургамалжуулна. Зарим барилгын үлдэгдлийг тэр хэвээр нь үлдээж засварлан малчдад малын хашаа, иргэдэд гаражийн зориулалтаар өмчлүүлж өгөх нь зүйтэй.
- Цэргийн зориулалттай ашиглаж хаягдсан газруудыг иргэдэд ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх замаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтыг татаж аж ахуйн эргэлтэнд оруулах нь зүйтэй. Ингэхийн тулд орон нутгийн захиргаа, газрын алба болон бусад холбогдох байгууллагууд санаачлага гарган идэвхитэй ажиллах шаардлагатай байна.

Мөн зарим газрыг аж ахуйн нэгж байгууллагад удаан хугацаагаар түрээслүүлэн өгч, тэднээр цэвэрлэгээ нөхөн сэргээлтийг хийлгэх арга хэмжээ авах нь зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Говьсүмбэр аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан, 2005 он
- “Шивээговь сумын 2020 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө” 2015он
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он
- Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
- Монгол улсын стандарт MNS 4652-28
- Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он
- “Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
- "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл
- “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
- “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 оны 5-р сарын 5
- “Иргэдийн оролцоотой газар ашиглалтын төлөвлөлт” УБ, 2006 он
- “Бэлчээр хадлангийн газрыг сайжруулах арга, тэжээлийн таримлын төрөл, сортууд” УБ, 2012он
- “Монгол малын зарим өвчтн, сэргийлэх арга зам” УБ, 2017он
- “Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй” УБ, 2005он
- “Газар тариалангийн цогцолбор аж ахуй байгуулах төсөл” УБ, 2016 он
- “Говьсүмбэр аймгийн Байгаль орчины төлөв байдлын тайлан 2014-2015он” 2017 он